МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
2	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	4-40
	1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	4-5
	2.“Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.01.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	5-5
	3.Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах ухай боло хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /хэлэлцэх эсэх/	6-40

ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

Гурав.Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн

***хуулийн төслүүд** /Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, **хэлэлцэх эсэх**/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн Байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Ч.Хүрэлбаатар, Х.Болорчулуун, Ж.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг, Н.Ганибал, Т.Доржханд, Д.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Ш.Адьшаа нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн нар хариулж, тайлбар хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Ч.Хүрэлбаатар, Т.Доржханд, Ц.Цэрэнпунцаг, Х.Болорчулуун, Ж.Бат-Эрдэнэ, Ш.Адьшаа, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Ж.Ганбаатар: Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 33 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 49 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Ж.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ Б.БАТГЭРЭЛ

ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Гурав.Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн хомстол, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Жавхлан сайд танилцуулна. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Баярлалаа. Эдийн засгийн Байнгын хорооны дарга Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Дэлхий нийт хөрөнгө оруулагч, халдварын эсрэг вакцинжуулалтыг амжилттай хэрэгжүүлснээр 2022 онд дэлхийн эдийн засаг эргэн сэргээж, цар тахлын өмнөх эдийн засгийн идэвхжлийн түвшинд эргэн хүрэх боломжтой гэж олон улсын байгууллагууд төсөөлж байлаа. Гэвч 2022 оны 2 дугаар сарын 24-нд Оросын Холбооны Улс болон Украин улсын зэвсэгт мөргөлдөөн эхэлснээр дэлхий нийтийн геополитик, эдийн засгийн нөхцөл байдалд урьдчилан тооцоолох боломжгүй хүндрэл үүсгээд байна. Олон улсын валютын сан /ОУВС/, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд 2022 онд дэлхийн эдийн засгийн өсөлтийг 4.3 хувь орчимд хүрнэ гэж төсөөлж байсан боловч дээрх нөхцөл байдлаас шалтгаалаад эдийн засгийн өсөлтийг бууруулан 3.5 орчимд тооцож байна. Оросын Холбооны Улсын экспортын голлох бүтээгдэхүүн болох байгалийн хий, газрын тос, үр тарианы үнэ дэлхийн зах зээл дээр огцом өсөж, нийлүүлэлтийн тасалдал үүсэх эрсдэл үүссэнээр импортлогч орнуудад шатахуун, эрчим хүч болон хүнсний бүтээгдэхүүний үнэд нөлөөлж байна. Улмаар БНХАУ-ын ургац 2022 онд буурч байгаатай холбогдуулан хүнсний нийлүүлэлтийн тасалдал гарч, дэлхий дахин хүнсний бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх, хангамжийн хомстол үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Иймд улс орнууд төсөв, мөнгөний бодлогыг уялдуулан дотоод нөөц боломжийг ашиглаж, гол нэр төрлийн хүнс, газрын тосны бүтээгдэхүүнд дэмжлэг үзүүлэх, нийлүүлэлт, хангамжийн хомстол үүсэх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авч байна. Түүнчлэн он гарсаар дэлхий нийтэд коронавируст халдварын тохиолдол нэмэгдэх хандлагатай бол байгаа нь дэлхийн эдийн засгийн нөхцөл байдалд улам сөрөг нөлөө үзүүлж байна. Одоогийн байдлаар дэлхий даяар нийтдээ 491 сая халдварын тохиолдол бүртгэгдсэнээс 2022 он гарснаас хойш 197 сая шинэ тохиолдол бүртгэгджээ. Тэр тусмаа сүүлийн жил гаруй хугацаанд халдварыг хяналтдаа оруулаад байсан урд хөршид маань тархалт огцом эрчимжиж, өнгөрсөн долоо хоногийн байдлаар өдөрт дунджаар 7145 тохиолдол илэрч, зарим томоохон хотуудад хатуу хөл хорио тогтоолоо. БНХАУ-д дотоодын тархалт нэмэгдсэний улмаас хилийн хориг тогтоосон болон Оросын Холбооны Улс, Украины нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн зах зээлд шатахуун, эрчим хүч, хүнсний үнэ нэмэгдэн Монгол Улсын инфляцын түвшин 2022 оны 2 дугаар сарын 14.2 хувь, Улаанбаатар хотын инфляцын түвшин 15.5 хувьд хүрээд байна.

Цар тахлын цаашдын төлөв байдал болон Оросын Холбооны Улс болон Украин улсын зэвсэгт мөргөлдөөн, Оросын Холбооны Улсад тавьж буй эдийн засаг, худалдааны хоригуудын үргэлжлэх хугацаа, олон улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, тодорхой бус нөхцөл байдал, түргэн хугацаанд эрс өөрчлөгдөж байгаа энэ цаг үед богино хугацаанд ард иргэдийн амьдралд хамгийн том нөлөө үзүүлдэг газрын тосны бүтээгдэхүүн, мах, гурилын хомстол үүсэх, үнэ өсөхөөс сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулж, онцгой журмаар зохицуулалт хийх зохицуулалтыг хуулиар Засгийн газар Монголбанканд олгох зайлшгүй шаардлага тулгараад байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт төрийн үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна гэж, мөн Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт Монгол Улсын Засгийн газар нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ гэж тус тус заасныг үндэслэн Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулж байна.

Хуулийн төсөлд дараах асуудлыг хэлэлцүүлэхээр тусгалаа. Үүнд Монгол Улсын Их Хурал гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, шаардлагатай нөөц бүрдүүлэхтэй холбогдсон хууль тогтоомжийн төслийг дараалал харгалзахгүй яаралтай хэлэлцэн шийдвэрлэнэ.

Хоёр.Монголбанкнаас мах, гурилын нөөц бүрдүүлэх, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мах бэлтгэн нийлүүлэгч, гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгөд шаардагдах хөнгөлөлттэй санхүүжилтийг, газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, үнийн өсөлтөөс сэргийлэх зорилгоор газрын тосны бүтээгдэхүүн импортлогчийн эргэлтийн хөрөнгийн болон урьдчилгаа төлбөр төлөхөд шаардагдах хөнгөлөлттэй санхүүжилтийг тус тус банкаар дамжуулан олгож санхүүгийн үүсмэл хэрэгсэлд ашиглана. Импортын төлбөрийн гадаад валютын ханшийн хэрэгслийг бууруулах арга хэмжээ авна.

Гурав.Монголбанкнаас гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор банкаар дамжуулан алт олборлогч аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгийн болон урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг олгож Лондонгийн металлын биржийн үнэ дээр 5 хувийн нэмэгдэлтэйгээр гадаад, дотоод зах зээлээс алт худалдан авна. Түүнчлэн Ашигт малтмалын тухай хуульд олборлосон алтаа тухайн санхүүгийн жилдээ багтаан тушаах үүргээ хэрэгжүүлээгүй зөрчсөн этгээдэд хууль хэрэгжих хугацаанд хариуцлага ноогдуулахгүй байх.

Дөрөв.Засгийн газраас мах, гурил, газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн хомстол үүсэхгүй байх арга хэмжээ авах цогц төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх.

Тав.Засгийн газраас мах гурилын нөөц бүрдүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох гэж шаардагдах хүүгийн татаасыг жилийн батлагдсан нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсөв хооронд төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хөрөнгийн болон урсгал зардал хоорондын төсвийн зохицуулалт хийх замаар шийдвэрлэх бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд хуульд заасан хязгаарын хүрээнд энэхүү хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын үнэт цаас, баталгаа гаргах арга хэмжээг авах.

Газрын тосны бүтээгдэхүүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт хангамжийн хомстол үүсгэхгүй байх ажлыг зохион байгуулах бөгөөд тусгай зөвшөөрөлтэй холбогдсон хариуцлагын гэрээ байгуулан мөрдүүлэх.

8.Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэгт заасны дагуу энэ хуульд заасан зохицуулалтад хамрагдсан хүнсний хангамж нийлүүлэлтэд хомстол үүсэхээс сэргийлж, экспортлох хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тухай бүр тогтоож бүрдүүлэх

бөгөөд энэ хуульд заасан хязгаар, зохицуулалтад хамрагдсан оролцогч талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тусгасан гэрээ байгуулан мөрдүүлэх зэрэг болно.

Хуулийн төслийг дагалдуулан Мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл, Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай Монгол Улсын Их Хурлын /99/ оны 27 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаа.

Эдгээр хууль тогтоомжийн төслөөр нэг,Монгол Улсын гадаадын иргэн, харьяалалгүй хүн 20 сая төгрөгөөс дээш төгрөгтэй тэнцэх хэмжээний гадаад валютыг Монгол Улсын хилээр бэлнээр гаргахыг хориглох, газрын тосны импортын гаалийн татварыг 5 хүртэл хувиар тогтоож, зохицуулалтын арга хэмжээ авах эрхийг Засгийн газарт олгох зэрэг асуудлыг тусгасан болно.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Ганбаатар: Жавхлан сайдад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Жавхлан сайд Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг гүйцэтгэгч, Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Баярдаваа, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал Энхжин, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Энхболд, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Уул нь хэд хэдэн сайд нар суух ёстой байсан юм байна. Ийм бүрэлдэхүүн байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулт. Их Хурлын гишүүд нэрсээ өгөхийг хүсье. Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Би санхүүгийн эх үүсвэртэй холбоотой асуудлыг асуух гэсэн юм. Миний ойлгосноор зөвхөн хүнс, хөдөө аж ахуйн хоёр бүтээгдэхүүний үнийн тогтворжуулалт дээр 200 орчим тэрбум төгрөг шаардлагатай гэж байсан. Нефть шатахууныг бол одоо үнийн дээшээгээ аль хүрч өсөхийг бол бид нар хэлж мэдэшгүй. Дэлхийн зах зээлээс л энэ бүхэн тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалах байх. Тэгэхээр түрүүлж тооцсон тооцоо байна уу? Энэ оныг дуустал ерөнхийдөө хэд орчим төгрөг гаргана, эх үүсвэрийг нь хаанаас тавина гэж бодож байгаа вэ? Энэ 10 их наяд энэ тэртэй ямар нэгэн байдлаар холбоотой хэрэгжилт энэ тэр байгаа юу гэдэг нэгдүгээрт эхний асуултыг тэгж асууя. Болохгүй бол нэмээд нь тодруулъя.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Их богинохон асуулт. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тийм, яг Булгантуяа гишүүний энэ асуулт бол олон давтагдана аа, олон гишүүд ер нь энэ асуултыг асуух байх. Ер нь нийтлэг байх ёстой асуулт юм байгаа юм. Өмнөх Үнэ тогтворжуулах хөтөлбөрөөс ялгаатай нь юу вэ энэ тэр гээд ингээд асуулт явна л даа. Хоёр зүйл дээр ялгаатай байгаа юм. Нэгдүгээрт Их Хурлаар нээлттэй, ил тод хэлэлцэнэ, нээлттэй, ил тод хэлэлцэнэ. Аль нэг институц бие дааж шийдвэр гаргахгүй, Засгийн газар ч тэр, Монголбанк ч тэр. Хуульчилж үнийг аль болох тогтвортой байлгахад Их Хурлын зүгээс, Засгийн газрын зүгээс, Монголбанкны зүгээс юу хийж болох вэ, ямар үүрэг хүлээх вэ, ямар үр дүнд хүргэх вэ? Мөн хувийн хэвшлийнхэн нийгмийн хариуцлагынхаа хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшдэг этгээдүүд ямар байдлаар яаж оролцох вэ гээд энэ зохицуулалтуудыг дурдсан ийм

хууль гэдгээрээ, хуулийн орчинд ингэж асуудал шийдэгдэнэ гэдгээрээ ялгаатай. Төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурал дээр хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, мөнгө төсвийн бодлогын энэ харилцан уялдаа холбоо дээрээс нь мөнгөний бодлого төсвийн бодлогоо уялдуулна гэдэг нэр дор хамаагүй хутгалдаж болохгүй гэдэг энэ алтан заагуудыг бас тодруулж оруулсан байгаа юм. Мэдээж мөнгөний бодлогын хатуу төлбөр рүү шилжчихсэн ийм үед мөнгөний нийлүүлэлтийг нэмэх байдлаар бусад ийм макро балансуудаа алдах, улс төрийн шахаанд оруулж Төв банкийг буруу, зөрүү ийм бодлогын бус шийдвэрүүдийг гаргуулах ийм зүйл бол хэрхэвч байж болохгүй. Тийм учраас нийлүүлэлтийг тогтвортой барихад хангахад чиглэгдсэн санхүүжилтийн эх үүсвэрүүдийг ер нь бүгдийг нь банкны эх үүсвэрээр харж байгаа юм. Банкны эх үүсвэрийг харин хөшиж гаргах хөшүүргүүдийг энэ хууль дээр боловсруулсан байгаа юм.

Шаардлагатай хүүгийн зөрүү, татан авчрахад гаалийн импортын татвар болон бусад өөр татваруудыг онцгой албан татвар гээд ийм ирэх боломжуудыг тусгай горимоор гэх юм уу, байнга Их Хурал дээр оруулаад ингээд хугацаа алдаад байх биш төрийн явах энэ хууль, шийдвэр гаргах процедуруудыг хөнгөвчлөх, хурдавчлах үүднээс Засгийн газарт эрхүүдийг нь олгох ийм замаар шийдэж байгаа гэсэн үг. Тэрнээс биш Төв банк мөнгөний нийлүүлэлт хийгээд тухайлан бэлтгэн нийлүүлдэг импортлогч компаниудад эх үүсвэр өгөөд байх ийм шаардлага бол байхгүй гарахгүй байх гэж бодож байна. Гарахгүй байх гэж бодож байна. Тийм учраас мөнгөний бодлого тал дээрээ мөнгөний нийлэлтээр эрсдэл учрах зүйл харьцангуй бага байна гэж ингэж харж байна. Тэгээд энийг ер нь энэ хуулиа хэлэлцэх, эхэнд нь ер нь нэг ийм дэлгэрэнгүй ойлголт өгөх нь зөв болов уу гэж ингэж бодож байна.

Ерөнхий хэмжээ гэх юм бол нэг ийм юм байгаа юм. Сардаа 100-120 сая доллар орчмын нийтдээ татан авалт хийдэг, импортын. Эндээс бол энэ хууль дээр тусгаагүй ч гэсэн яг нарийвчлан гүйцэтгэх шатандаа ороод ирэх юм бол бүх төрлийн бензин шатахуун дээр оролцохгүй, зөвхөн өргөн хэрэглээний 92 дээр л оролцъё гэж байгаа юм. Зөвхөн 92 дээр татан авалт дээр нь. Тэрэн дээр нь санхүүгийн үүсмэл хэрэгслүүд дээр тогтвортой ханшаар валют нийлүүлэх, мөн банкны өөрийнх нь хязгаарлалт байдаг, 20 хувиас хэтэрдэг. 20 хувиас хэтэрсэн тохиолдолд тэр хэтэрсэн хэсэг дээр Засгийн газрын баталгаа олгох, эргээд төлөгдөхдөө эхлээд Засгийн газрын баталгаагаа суллах гэдэг иймэрхүү зарчмуудаар импортлогч нартай хамтарч ажиллана гэсэн үг.

Ж.Ганбаатар: Булгантуяа гишүүн тодруулъя.

Х.Булгантуяа: Тэгэхээр хөнгөлөлттэй эх үүсвэр, зах зээлийн ханш хоёрын хоорондын зөрүүг улсын төсвөөс шийдэх юм уу гэдэг ийм л асуулт байгаад байгаа юм л даа. Одоо энийг чинь хөнгөлөлттэй эх үүсвэрээр, тэгээд урьдчилгаа байдлаар өгнө, аж ахуйн нэгжүүдэд зээлдүүлнэ, энэ санхүүжилтийн эх үүсвэрийг гаргана гээд байгаа юм. Үүнийг Монголбанк өөрөө шууд 100 хувь хариуцаад явж чадах юм уу? Төсөв дээр үүнтэй холбоотой зохицуулалт хийх юм уу гэдэг ийм асуулт байна.

Ж.Ганбаатар: Их богинохон асууж сурч байна шүү тийм ээ. Дэгийн тухай хуульд хуульд асуулт нь хариулттайгаа дөрвөн минут болгоё гээд, тэр бас их зүгээр. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Хуулийн дээр шатахууны хэсэг дээр Засгийн газрын бүлэг үүрэг дотор маш тодорхой заачихсан байгаа. Зээлийн эх үүсвэрийг бол банкаар дамжуулж, хөнгөлөлттэй очихын тулд хүүгийн татаасыг төсөв дотроо зохицуулалт хийж Засгийн

газар хариуцаж олгохоор ингэж заасан байгаа. Тэрнээс биш тэр зээл дээр зөвхөн банкны эх үүсвэрээр гарна гэдэг ийм зохицуулалт байгаа юм.

Ж.Ганбаатар: Зүгээр нэг зүйл хэлэхэд, яг тавигдаж байгаа асуудал бол нэлээн оройтсон шүү. Цаг хугацаа алдсан. Энэ байдлуудыг чинь намраас л ярьсан биз дээ? Засгийн газар дээр яригдаад л байгаа сураг байсан. Хүрэлбаатар гишүүн асуулт асууя.

Ч.Хүрэлбаатар: Их л олон юм асуумаар байна. 2022 онд бол манай улсын эдийн засагт тулгамдаж байгаа гол асуудал бол үнийн өсөлт. Тэгээд энэ үнийн өсөлтийг яаж шийдэх вэ гэсэн чинь мөнгө хэвлэж шийднэ гээд юм оруулаад ирж байгаа юм, одоо. Мөнгө хэвлэж үнэ тогтворжуулдаг юмыг би л лав мэдэхгүй юм байна. 2013-2016 оны хооронд Алтанхуягийн, Сайханбилэгийн Засгийн газар, Монголбанкны ерөнхийлөгч Золжаргал гэдэг хүн байхад ийм юм хийж, Монгол Улсын эдийн засгийг сонгодог утгаар нь алсан юм байгаа юм. Тэгээд тэр давтагдах гээд байна л даа. Энэ чинь өөр зөндөө олон шийдэл байна шүү дээ. Тэр шийдлүүд дотроос хамгийн болохгүйг нь, улс орноо хорлоё гэсэн юм шиг юмыг нь оруулж ирэхийг би үнэхээр ойлгохгүй байна.

Та бүгд заалтаа уншаад үзье л дээ. Тэр 5 дугаар зүйл дээр Монголбанкнаас авч хэрэгжүүлэх гэдэг дээр. Тэгээд л 5.1.5 санхүүжилтийг банкаар дамжуулна олгоно, санхүүжилтийг банкаар дамжуулан олгон эрсдэлийг бууруулна, урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг олгоно, тусгайлан тогтоон улсын нөөцийг нэмэгдүүлэхээр алтыг зах зээлийн үнээс өндөр үнээр авна гэх мэтийн юмнууд орж ирж байгаа юм. Монголбанканд ямар мөнгө байдаг юм? Монголбанк чинь баялаг бүтээгч биш. Өөрийн гэсэн мөнгө байхгүй. Тэгэхээр мөнгөний эх үүсвэр нь хэвлэхээс өөр арга байхгүй. Хэвлэхийг Монгол Улсын хуулиар хорьчихсон шүү. Тэгээд сая хэвлэхгүй гээд байх шиг байна. Ар тал дээрээ бас тийм заалт нь байна шүү дээ. Энэ хуулийг хэрэгжүүлснээр Монголбанкны пассив нь актив хөрөнгөөс хэтэрсэн тохиолдолд үнэт цаас гаргах зам уг зөрүүг нөхнө гээд. Мөнгө хэвлэнэ гэсэн үг энэ чинь. Тэгэхээр энийгээ болих хэрэгтэй байна.

Хоёрдугаарт нь, ингээд мөнгө хэвлэе, яг энүүгээр хэвлээд. Та нар энэ аж ахуйн нэгжүүдэд мөнгө олго. Мөнгө олгоно гэж байгаа шүү дээ, мөнгө өгнө гэж байгаа юм. Тэр мөнгө хаанаас гарах юм? Улсын төсвөөс гаргахгүй. Тэгэхээр Монголбанкнаас гарна. Монголбанк хаанаас гаргах юм? Хэвлэж өгнө. Өөр ийм юм энэ дээр харагдахгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр 2013-16 онд мөнгө хэлж байх үед юу болсон юм бэ гэхээр бүх юм очиж энэ валютын нөөцийг шавхдаг ханш явж өгнө, дээшээгээ ханш. Одоо та нар хоёр ханштай явж байна шүү дээ. Эрх мэдэлтэй хүмүүсүүдэд нь бол 2900-гаар энэ валютын ханш аваад байх шиг байна.

Ард иргэд, бизнес эрхлэгчдэд та нарын тэр хэлээд байгаа 2900 ханштай доллар чинь олдохгүй байгаа. 3200-тай ханш ард иргэдэд олдож байгаа, аж ахуйн нэгжүүдэд. Тэгээд хоёр өөр ханш байна гэдэг чинь долларыг зарцуулах эрх мэдэлд ойрхон байгаа. Хүмүүс нэг доллар дээрээс 300 төгрөгийн ашиг унагааж бизнес хийж байгаатай яг адилхан ийм зүйл явагдаад байгаа юм. Тэгэхээр мөнгө хэвлэвэл энэ улам гарна. Мөнгө хэвлэж эхлээд 1360 ханш 2000 гараад явсан шүү дээ. Тэгээд 2000 дээр нь барих гэж өчнөөн их нөөцөө зарсан. Бодитоор бол 2400, 2500 руу гарчихсан л байсан. Тэгээд энэ чинь ингэж явагдаж байна. Энэ бол буруу.

Дараагийн асуулт нь Монголбанкны Ерөнхийлөгч тэр хууль зөрчиж Үндэсний хөрөнгө оруулалтын банканд 14 тэрбум төгрөг олгосон. Энэ эргэ төлсөн үү?

Гуравдугаарт нь, импортын хувь хэмжээг тогтоох эрхийг Засгийн газар авна гэж байгаа юм. Импорт дээр бол хэрэггүй шүү дээ. Экспортлох дээрээ л хориг гэсэн тэр

нэрээ зарлана гэсэн нэг юм энэ дээр байж байна. Импортын, Их Хурлын эрхийг авч яах гэзд байгаа юм. Буруу замаар будаа тээвэл буцахдаа шороо.

Ж.Ганбаатар: Лхагвасүрэн ерөнхийлөгч, ажлын хэсгийн 5 номер. Гишүүний асуултад хариулъя.

Б.Лхагвасүрэн: Хүрэлбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Монголбанкны зүгээс бол мөнгө шинээр хэвлэж нийлүүлэхгүй л гэж харж байгаа юм. Өнөөдөр бол Монголбанкан дээр репо санхүүжилт гэзд хэрэгсэл байдаг. Монголбанкны үнэт цаасыг барьцаалаад банкнууд өөрт нь байгаа эх үүсвэрээ буцаагаад цааш нь олгодог. Тэгэхээр Засгийн газрын эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх энэ хөтөлбөр ч гэсэн энэ замаар явсан. 2 их наяд төгрөгийн хэмжээнд 3 хувийн зээл олгосон. Энэ бол Төв банкны үнэт цаасан дээр байсан эх үүсвэр өнөөдөр 6.5 их наяд болоод 10 их наядаас ингээд буурчихсан байгаа нь ерөнхийдөө энэ мөнгө өөрөө буцаад эдийн засаг руу орсон гэдгийг л илтгэж байгаа юм. Тэгэхээр яг энэнтэй адилхнаар, угаасаа банкан дээр байгаа мөнгийг хэрвээ яг энэ хуулийн дагуу тэр мах бэлтгэл юм уу, эсхүл намрын ургац хураалт, энэ намрын тариалалтад ашиглах бол энэ мөнгө л тэр аж ахуйн нэгж рүү очно.

Нефть бүтээгдэхүүний хувьд бол өнгөрсөн оны намраас эхлээд энэ нефтийн Засгийн газрын тогтоолоор 45 хоногийн нөөц барихаар ийм арга хэмжээ явагдаж байгаа. Өнөөдрийн байдлаар бол энэ нефть импортлогч компаниуд бол 38-45 хоногийн нөөцийг бол барьчихсан байна гэдгээрээ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны мэдээлэл дотор ингээд явж байгаа. Энэ хуулийн хүрээнд энэ нөөцийг улам цааш нь нэмэгдүүлээд ямар ч байсан олон улсад гарсан энэ хурцадмал энэ хямралтай нөхцөл байдлын үед, ялангуяа нефтийн бүтээгдэхүүн Монгол Улсад 100 хувь хараат байдаг энэ бүтээгдэхүүний нөөцийн хомстлыг бий болгохгүй. Дээр нь үнэ бол их савлагаатай байгаа энэ хямралаас болоод. Зарим үед 140 баррель нь торх нь 130 ам. доллар хүрч байгаа, зарим үед 110, 120 доллар болж байгаа. Тэгэхээр энэ үед аль болохоор хөнгөлөлттэй үнээр авчраад тодорхой хугацаанд нөөцөлье гэж ярьж байгаа. Энэ нь бас л репо санхүүжилт ээр явж байгаа учраас энэ дээр бол нэмж мөнгө хэвлэгдэхгүй л гэж харж байгаа.

Нефтийн бүтээгдэхүүний хувьд бол нөөц бүрдүүлнэ гэдэг маань ирээдүйд гарах мөнгийг одоо өгч байна гэдгээ л харж байгаа учраас бол энэ дээр одоо ер нь ямар нэгэн зүйл гарахгүй байх л гэж харж байгаа. Инфляцын хувьд бол мэдээж мөнгө хэвлэгдэхгүй гэдэг утгаараа манай өнөөдрийн инфляц бол ерөнхийдөө 50 хувь нь бол импортоор орж ирж байгаа инфляц байгаа. Тэгэхээр одоо ялангуяа нефтийн бүтээгдэхүүн бол өнөөдөр инфляцад бол 20 хувийн нөлөөтэй, мах бас 20 хувийн нөлөөтэй. Гурил бол 10 хувь буюу 2 нэгж хувийн ийм нөлөөтэй байдаг учраас хэрвээ эдгээр бүтээгдэхүүний үнэ тогтвортой байх юм бол нөөц нь бүрдээд, тэгвэл инфляц энэ хэмжээгээр бол тогтворжино л гэж харж байгаа юм. Үндэсний хөрөнгө оруулалтын банкны хувьд бол Монголбанкнаас Монголбанкны барьцаа, зээлийн журмаар 90 хоногийн хугацаатай зээл аваад сая хугацаа нь дууссан. Банкны зүгээс бол сунгая гэж байгаа. Сунгах нь бол журмаараа ахиад 60 хоног сунгах л ийм эрхтэй.

Ч.Хүрэлбаатар: Хугацаандаа төлсөн үү?

Б.Лхагвасүрэн: Тэгэхээр бол төлөөгүй, сунгая гэдэг хүсэлт тавьсан юм. Ханшийн хувьд бол банк хоорондын зах маань өөрөө нийт Монгол Улсын валютын захын 95-98 хувь нь банк хоорондын зах дээр байдаг. Найман шарга буюу бэлэн бэлэн валютын зах бол 2-3-хан хувьтай. Тэгэхээр өнөөдрийн ханш бол бэлэн болон бэлэн бусын л ханш байна гэж Төв банкны зүгээс харж байгаа. Яагаад гэвэл өнөөдөр ингээд банкнууд банк хоорондын захаас болон Монголбанкны дуудлага худалдаагаар авч байгаа энэ

мөнгөнүүд бол голцуу дандаа гадаад төлбөр тооцоо буюу бэлэн бус төлбөр тооцоонд ашиглагдаж байгаа. Төв банкны зүгээс бол бэлэн валютын нөөцийн хомстолтой гэдэг утгаараа Төв банкнаас банкнуудад бол бэлэн валют өгдөггүй. Тэгэхээр бэлэн валют болон бэлэн бус валютын ханшийн л зөрүү байна гэж харж байгаа юм.

Ж.Ганбаатар: Хариулах уу? Жавхлан сайд хариулъя, 2 минут.

Б.Жавхлан: Хүрэлбаатар гишүүний асуултад хариулъя. Тэр нь татвартай холбоотой. Тухайлбал, шатахуун дээр бол бид нар өмнө нь энэ Засгийн газраас авч хэрэгжүүлж болох татварын хөнгөлөлтүүд, онцгой албан татвар ер нь бүгдийг нь нэрлэчихсэн байгаа юм. Ганцхан үлдсэн юм маань дизель дээр онцгой албан татвар дундаж энэ 1000 төгрөг гээд байж байгаа. Одоо бид бусад нэр төрлийн бараанууд махан дээр тэр, гурил дээр ч тэр үлдэж байгаа зүйл маань гаалийн импортын татвар 5 хувь гээд байж байгаа. Тэгэхээр юмыг яаж мэдэх вэ, ийм нэмэлт боломж зохицуулалтын ийм тохиргоотой байя гэж байгаа юм. Их Хурлаас эрхийг нь ингээд шууд шилжүүлж авч байгаа зүйл огт байхгүй.

Төрийн гаргаж байгаа энэ шийдвэрүүдийн хурдыг л бид нар зохицуулалт хийгээд л түргэсгэж байгаа юм. Тэгээд ч хуулийн хугацаа үйлчлэх энэ хугацаандаа л гэсэн үг. Энэ он дуустал. Шаардлагатай бол гаалийн импортын татварыг нь тэглэх замаар тэр хэмжээний зардлыг нь өртгийг нь бууруулъя гэсэн, ийм нэмэлт машинаар бол нэмэлт дараа л авч үлдэж байна гэсэн үг юм байгаа юм.

Ж.Ганбаатар: Хүрэлбаатар гишүүн тодруулъя.

Ч.Хүрэлбаатар: Лхагвасүрэн ерөнхийлөгч өө, энэ мөнгө хэвлэж байна шүү дээ, та нар. Хэрвээ мөнгө хэвлэхгүй гэж хийвэл яаж хийх вэ гэдгийг би хэлээд өгөх үү? Арилжааны банкнууд тэр аж ахуйн нэгжүүддээ зээлээ олго. Хүүгийн зөрөөг нь төсөв дээрээ тавиад тэрийг нь өг. Ингээд л боллоо. Монгол Улсын бүх хуульд нийцнэ. Тэгээд төсвийнхөө тодотголыг өргөчих. Ямар ч зовлонгүй шийдэл энэ. Гэтэл заавал мөнгө хэвлээд валютын нөөц рүү дайрах, тэгээд урьд өмнө нь хамгийн үр дүнгүй, ямар ч үр дүн гараагүй өчнөөн хүн эрүүгийн хэрэгт холбогдуулаад шалгагдаж байгаа зүйл дээр яг тэр аргыг хэрэглэнэ гээд оруулаад ирж байгаа юм. Болохгүй шүү дээ, ингэж. Хоёрдугаарт нь, ер нь сүүлийн 30-аад жил ийм хоёр ханштай байгаагүй биш, Лхагвасүрэн. Өөрийн чинь үед л бий болж байна. Тайлбарууд чинь бүгд худлаа. Тийм учраас наад арга замууд, аргаа өөрчил.

Ж.Ганбаатар: Хүрэлбаатар гишүүн үг хэллээ. Болорчулуун гишүүн асуулт асууя.

Х.Болорчулуун: Засгийн газраас зарим нэр төрлийн гол барааны үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх ийм хууль энэ төсөл оруулж ирж байна аа. Үнэхээр бид нар бас олон жил ярьж байна. Тэгэхдээ яг энэ хямралт байдал, тэр хомстлоос бас даацтай сэргийлж чадахгүй, ажиллаж чадахгүй л байна л даа. Та бүхэн санаж байгаа байх. Арваад жилийн өмнө Баяр ерөнхий сайд байхад Оросын Холбооны Улс будаа гурилынхаа импорт дээр хязгаарлалт тавьчихсан байсан, экспорт дээр. Тэгээд тэднийд очиж гурил гуйгаад, “үгүй ээ, хүнээс хоолоо гуйна гэдэг чинь ямар ичгүүртэй юм бэ” гэж хэлж байсан. Яг тэр байдал өнөөдөр байж л байна шүү дээ. Цаашлаад гурил, будаагаа битгий хэл, бензин тосоо хүнээс гуйдаггүй болох юмсан л гэж ярьж байсан. Тэр нөхцөл байдал өнөөдөр арваад жилийн дараа байж л байна.

Энэ бол үе үеийн дараачийн Засгийн газрууд үндэсний үйлдвэрлэлээ даацтай дэмжихгүйгээс болж байгаа юм. Тухайн үед нь л аргалаад л саяын Жавхлан сайдын хэлдгээр нөгөө импортын татвараа л ярьж байна. Энэ чинь үндэсний үйлдвэрлэлээ үндсээр нь дампууруулдаг байхгүй юу энэ нолилох /0/ чинь. Гэнэтхэн энэ Украин, Орос

энэ тэр чинь дайн байлдаантай байна. Дэлхийн 70 хувийг будаа хангадаг газар. Эд нар экспортод гаргах хязгаарлалт хийхэд манайх яах юм?

Өнөөдөр газар тариаланчдын тал нь дампуурчихлаа. Өнгөрсөн жил 100 сая орчим долларын гурилыг импортоор худалдаж авсан Оросоос. Тэгээд Монголынхоо газар тариаланчдын будааг голж шилээд, тэгээд бараг авахгүй, зарим нь складандаа ингээд дампуурсан. Тэгтэл Засгийн газар, Сангийн сайд дахиад нөгөө импорт л гээд яриад байгаа юм. Энэ хууль дээрээ 6.1.3-аар импортын татварыг тэглэх, бууруулах асуудал ороод ирж байгаа юм. Бид газар тариаланч нараа дэмжиж байж цаашдаа энэ гурил, будааны үнэ чинь тогтвортой байна. Тэрнээс гурилын үйлдвэрт энэ татаас өгөх асуудал орж байна. Хөнгөлөлттэй зээл. Битгий татаас өг. Тэр тусмаа импортоор авч байгаа гурил дээр битгий өг өө, будаан дээр битгий өг. Импорт оргож байгаа гурил будаан дээр. Би энийг хүсэж байна.

Харин газар тариалан дотоодын үндэсний үйлдвэрлэл, дотоодын газар тариалангаасаа авсан будаа, түүгээр хийсэн гурил дээр нь харин хөнгөлөлттэй зээл өг. Ингэж ялгамаар байна. Тэгэхгүй бол хэдэн долларыг чинь гадагшаа гүвээд энэ газар тариаланчдаа ингээд дампуурлын байдалд оруулж байна. Энийг бас ойлгож Засгийн газар ажиллаасай гэдгийг бас хэлж байна хэлэх байна.

Ер нь яагаад Израиль элсэн цөл дээр хүнсний ногоог өөрсдөө хангах бодлого явуулж байна, амжилттай ажиллаж байна? Яагаад Япон өөрийн талбай дээр тарьснаас Хятадаас авахад 200 хувийн хямд гэж байгаа юм, 200. Гэтэл би тэрийг асууж байсан, Японы хөдөө аж ахуйнхнаас. Нэгд нь, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнийг гаднын хараат байж болохгүй. Хоёрт, тэр 200 дахин хямд авснаас илүү энэ тариалагчид ажил ажилгүй бол эдийн засгийн хямрал нүүдэллэнэ, ажилгүйдэл ядуурал нь нүүрлэнэ гэж хэлж байсан нь одоо бүр санаанаас гардаггүй. Би ч урьд нь хэлж байсан.

Тэгтэл манайх бол зөвхөн тав, арван хувийн хямдыг нь бодоод л үндэсний үйлдвэрээр дамжуулаад дампууруулаад, цаашдаа тэр улс оронд нь ажилгүйдэл, ядуурал үүсэж байгаа юмыг эдийн засгийн тооцоо байхгүй байна аа. Сангийн яам, одоо шинэ байгуулагдсан Хөгжлийн яам энэ дээр л тооцоо хийж байх ёстой. Би тэр энэ хуулиийн 6.1.3 гаалийн импортын татварыг зохицуулалт хийнэ гээд. Энийг бол хасах хэрэгтэй гэсэн саналтай байна шүү. Шатахуун дээр бол болно. Шатахуун дээр гэж тавиарай.

Би дахиж хэлье. Ноднин Оросоос будаа авахдаа тонныг нь 800 мянгаар авсан. Дотоодын будаагаа.

Ж.Ганбаатар: Болорчулуун гишүүнд 1 минут сунгаж өгье.

Х.Болорчулуун: Өнгөрсөн жил Оросын Холбооны Улсаас улс улсаас нь валют зараад улаан буудай авахдаа 800-850 мянгаар 1 тонн авсан. Тэгтэл Вонголын газар тариаланч;аа доош нь хийгээд 600-650 мянгаар авч ингээд дампууруулсан шүү гэдгийг бас давтаж хэлмээр байна. Тэгэхээр цаашдаа энэ гурил. талхны үнэ тогтвортой байлгая бол гурилын үйлдвэрт зээл өгөхөөсөө илүүтэй газар нь тариаланчдаа сайн дэмжих хэрэгтэй байна гэдгийг бас дахин давтаж хэлмээр байна.

Түүнээс гадна түрүүн Хүрэлбаатар гишүүн хэлсэн. Хууль зөрчөөд 14 тэрбумыг Үндэсний хөрөнгө оруулалтын банканд өгсөн гээд Монголбанкны ерөнхийлөгчөөс асууж байна. Энэ ямар хууль зөрчсөн юм? Үнэхээр хууль зөрчсөн юм бол Монголбанкныхан тэгээд хариуцлага хүлээхгүй ингээд байгаад байдаг юм уу? Хугацаандаа төлөөгүй, дахиад сунгах хугацаа ярьж байна гэж. Тэгж болдог юм уу? Улс

төрчдийн эрх мэдэл бүхий албан тушаалтны банк нь болохоор тэгээд тэрбум тэрбумаар нь Монголбанкнаас улсаас авчихдаг.

Ж.Ганбаатар: Жавхлан сайд гишүүний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Баярлалаа. Болорчулуун гишүүний асуултад хариулъя. 6.1 дэх заалт нь зөвхөн шатахуунтай холбоотой зохицуулалт юм байгаа шүү. Тэр гаалийн тариф нь. Бусад бүтээгдэхүүн дээр бол байхгүй байна. Тэрийг тодруулъя. Гэхдээ Болорчулуун гишүүний ярьсан тэр ерөнхий агуулгатай би бас өөрийнхөө бодлыг хэлье. Өнөөдөр бид нар аргаа барсан л арга хэмжээ авч байгаа юм.

Ер нь олон жилийн бид нар буруу бодлого явж ирсэн. Дотоодын үйлдвэрлэл, ялангуяа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн дээр дотоодоо цэвэр хангах, улмаар экспортод гаргах, төмөр замаа бариад бид хангалттай экспорт хийж, валютын нөөцөө зузаатгаж чадаагүй. Гашуунсухайт дээр гаргасан нийт экспортынхоо бараг талыг нь далд эдийн засагт аваачаад алдчихсан. Тэгж өнөөдөр бид нар эдийн засгаа хүчтэй байлгах боломжуудаа алдсан юм байгаа юм. Тийм учраас өнөөдөр энэ хүнд үед бид маш эмзэг бөгөөд тэрнийхээ төлөө маш их үнэтэй мөнгө төлөх болж ирж байгаа байхгүй юу.

Одоо ер нь хүнсний бүтээгдэхүүн дээр гэхдээ энэ импортын тариф дээр бас тэглэх үү, яах вэ гээд асуудал бас бид судалж байгаа. Шийдвэр гаргах, санал өгөх болоогүй байна. Тэгэхдээ судалж байгаа зүйл байгаа. Энэ аргаа барьсан арга хэмжээ, үнэн. Би нэг талаар Болорчулуун гишүүнтэй санал нийлж байна. Дотоодын үйлдвэрлэгч нарт цохилт ирнэ. Цохилт ирнэ, мэдээж. Гэхдээ өнөөдрийн тулгамдчихсан асуулт нь бас ингээд нийлүүлэлтийн шок юм байгаа юм. Олон жил дотоодын үйлдвэрлэгч нартаа тогтвортой нийлүүлэлтээ хангаж чадах тэр юмыг нь авчирч чадаагүйнхээ төлөө, бодлогын алдааныхаа төлөө л бид нар ийм мухардмал байдалд орж ирж байна гэсэн үг. Цаашдаа бол ийм импортын татварыг тэглэх хүртэлх ийм хурдсан арга ядсан арга хэмжээ авах байдалд хүрэхгүй тийм эдийн засгийнхаа дотоодын үйлдвэрлэлээ хүчтэй болгох энэ бодлого маань бол хэзээ ч хаягдаж болохгүй.

Энэ удаа бол энэ жилийн хувьд онцгой ийм зэвсэгт мөргөлдөөний нөлөөллүүд орж ирсэн богино хугацааны ийм нийлүүлэлтийн шокоо давах ийм арга хэмжээнүүд шүү гэдгийг тодотгож хэлье. Тэгээд энэ удаа энэ хууль дээр бол зөвхөн тэр тариф гаалийн тариф бол шатахуун дээр шүү.

Ж.Ганбаатар: Монголбанкаас асуусан уу? 5 номер, гишүүний асуултад хариулъя.

Б.Лхагвасүрэн: Болорчулуун гишүүний банктай холбоотой асуултад хариулъя. Энэ бол хууль байдаг. Дээр нь Монголбанкны журам байгаа, барьцаат зээлийн журам. Энэ журмынхаа дагуу л явж байгаа юм. Тэгэхээр 90 хоногоор зээл аваад тэгээд төлөгдөөгүй байгаа. Тэгээд хугацаагаа сунгая гэсэн хүсэлт 60 хоногоор. Одоо сунгах бол 60 хоногийн л хугацаа байгаа юм. Энэ 60 хоногтоо төлөгдөхгүй бол барьцаа хөрөнгөөр нь барагдуулах үйл ажиллагаа яг л тэр журмынхаа дагуу явагдана.

Ж.Ганбаатар: Ж.Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ гишүүд ч бас ерөнхийдөө агуулгыг нь яриад л байх шиг байна л даа. Бид нар чинь одоо дотоодын үйлдвэрлэлээ дэмжээгүй, аж ахуйн нэгжүүдээ дэмжих, иргэдээ дэмжээгүйгийн л хар гай гэх юм уу даа. Ийм үр нөлөөлөл өнөөдөр гарч байна шүү дээ. Гадаадын нэг их айхтар нөхцөл гэхээсээ илүү одоо жишээ нь, энэ чинь махны үйлдвэртэй холбоотой улс бол махны хангамж байна, дотоодын

үйлдвэртэй холбоотой гурилын асуудал байж байна. Шатахуун бол ойлгомжтой гаднаасаа шалтгаалдаг юм байгаа биз.

Тэгээд би гишүүн болсноосоо хойш бол Сангийн сайд нартай, Хүрэлбаатар сайд ч хажууд сууж байна, одоо Жавхлан сайд. Ер нь аж ахуйн нэгжүүдээ дэмжих ёстой, аж ахуйн нэгжүүдийг дэмжихэд ямар төсөв дээр ямар дэмжлэг байх юм бэ, үйл ажиллагааг нь явуулахад дэмжлэг юу байх юм бэ гээд л маш олон удаа ярьсан даа. Тэгээд аж ахуйн нэгжүүд ер нь зах зээлийнхээ журмаар явах ёстой гээд шинэ сайд маань ч тэгж байсан, урьдны сайд ч тэгж л байсан. Одоо жишээ нь махан дээр, гурилан дээр энэ чинь цэвэр дотоодын бүтээгдэхүүний үйлдвэрлэл шүү дээ. Цэвэр дотоодын үйлдвэрлэлээ дэмжээгүй л асуудал шүү дээ. Махны үйлдвэрлэл одоо яах юм. Энэ чинь өөрсдөө 70-аад сая малтай гээд л том, том яриад л байдаг. Тэгсэн мөртөөө өөрсдийнхөө махныхаа үйлдвэрлэл, махныхаа хангамжийг дайн байлдаантай холбоно гэдэг чинь одоо ямар утга учир байгаа юм?

Энэ жил 570-аад байгаа байх аа, Хөдөө аж ахуйн яамныхан уг нь орж ирсэн бол энэ өөрсдийнх нь асуудал байж байх юм. 570-аад мянган тонн үр тариа хурааж авсан. Энэнээс бараг сүүлийн үед энэ тариаланчид нэлээн үгүй хэл болоод байгаа шүү дээ. Яах вэ, байгалийн шалгарлаар тэр будаа, тариа нь наана, цаана гээд чанартай, чанаргүй асуудал байсан байх. Гэхдээ л бараг л 70-аад хувь нь борлогдоогүй энэ агуулгатай байж байгаа л гээд байгаа шүү дээ. Энэ дээр ямар нэгэн арга хэмжээ авч болохгүй байсан юм уу. Чанартай, чанаргүй ч гэсэн гурилынхаа үнийг гурилынхаа, хангамжийг энэнтэй нь уялдуулаад нэмэгдүүлэх боломж бололцоо байхгүй байсан юм уу гэсэн нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, энд шаардагдах хөнгөлөлттэй санхүүжилтийг банкаар дамжуулан олгоно оо. Банкаар дамжуулах чинь зөв өө. Гэхдээ ямар хөнгөлөлттэй санхүүжилт юм бэ? Нөгөө 3 хувийн зээл юм уу, эсвэл өөр бас үнэ хөнгөлөлттэй санхүүжилт байгаа юм уу? Энийгээ тодорхой гаргахгүй юм уу. Хэрвээ 3 хувь гээд түрүүний гаргасантайгаа адилхан тэрэнтэйгээ уялдуулах юм бол нөгөө зөрүү хөрөнгөө яах юм? Түрүүн бас Хүрэлбаатар гишүүн хэлэх шиг боллоо. Зөрүүг Засгийн газраас гаргах байдаг юм уу, ямар нэгэн байдлаар баталгааг нь хүүгийн зөрүүг нь өгөх ийм боломж бололцоо нь хэд байгаа юм? Энэнд нь хэдэн төгрөг оролцох юм, эсвэл өөр ийм хөнгөлөлттэй санхүүжилт гэсэн ямар санхүүжилтийн эх үүсвэр байгаа юм. Энэ санхүүжилтийн эх үүсвэр түрүүн Булгантуяа гишүүн ч бас асуух шиг болно. Тэгэхдээ олигтой хариулт авсангүй л гэж хараад байна. Санхүүжилтийн эх үүсвэр чинь яг ямаршуу байх юм, хаанаасаа гарах юм. Тэгээд банкаар дамжих юм байна. Хөнгөлөлттэй гэдэг нь ямар учиртай юм бэ гэдэг ийм хоёр асуулт. Ямар нөхцөлтэй зээл юм бэ гэдгийг.

Ж.Ганбаатар: Монголбанк, 5 номер.

Б.Лхагвасүрэн: Ганбаатар Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Бид нар энэ тооцоолол судалгааг хийж байхад бол Хүнс, хөдөө аж ахуйн яаман дээр, ялангуяа гурил юм уу, махан дээр санхүүжилт хийе гэж банкнууд бол саналаа өгсөн байна лээ. 13-14 хувийн ийм зээл олгоход бэлэн байна гээд. Өнөөдрийн зах зээлийн хүүгийнх нь нөхцөл нь энэ. Тэгэхээр ийм хүүн дээр аж ахуйн нэгжүүд дээр нь 50 хувийн татаасыг нь улсын төсөв дотор суулгаад явъя л гэсэн ийм тооцоолол явж байна лээ.

Ж.Ганбаатар: Тодруулах уу? Ж.Бат-Эрдэнэ.

Ж.Бат-Эрдэнэ: Одоо наад юм чинь гарч ирж байна шүү дээ. Ямар хэмжээний татаастай байх юм, 50 хувь гэж байна. Энэ чинь энэ хууль дээр чинь харагдахгүй байгаа байхгүй юу. Хөнгөлөлттэй л гээд байна. Энэ чинь тодорхой л байх хэрэгтэй байхгүй юу даа. Тэр гурил, будаатай холбоотой асуудлыг хэдий хэмжээний буудай

үлдсэн, үлдэгдэл хэд байгаа, тэр нөөцөө ашиглах тийм боломж бололцоо байгаа юм уу, үгүй юу, Хөдөө аж ахуйн яам тийм хариулт байна уу, Сангийн яам?

Ж.Ганбаатар: Урьдчилсан мэдээлэл дээрээ, Жавхлан сайд мэдэж байгаа байх. 7 сарын 1 хүртэл бол нөөц байгаа гэж хариулна лээ. Жавхлан сайд гүйцээгээд хариулчихъя. 2 минут, Жавхлан сайдын микрофон өгье.

Б.Жавхлан: Махан дээр бол ийм байгаа юм. 7 сарын 1 хүртэл ямар ч байсан Улаанбаатар хотод махны нөөц бүрдүүлэлт бол хангалттай хийгдсэн. Энэ үнийг бол бас тогтвортой байлгах, шаардлагатай бол нэмж нөөц бүрдүүлэх ийм л асуудал байгаа. Хуулийн хэрэгжих хугацаа бол он дуустал. Тэгээд 7 сарын 1-нээс хойш нөхцөл байдал ямар болох нь вэ, мэдээж дотоодын нийлүүлэлт долоон сараас хойш бол харьцангуй нэмэгддэг. Мах хямдардаг ийм үе. Тэрэнтэй залгуулах нь их чухал байгаа юм. Махны хувьд бол ийм байгаа юм. Өөрөөр хэлбэл шатахуунаас арай өөр, бүтэц нь. Дотооддоо бид үйлдвэрлэдэг учраас.

Гурил дээр ийм байгаа, өмнөх жилүүдийн хуримтлагдсан нөөц, гурилын үйлдвэрүүдэд байгаа нөөц, гурилын үйлдвэрүүд нөөцтэй байгаа учраас нэмж тариаланчдын гар дээр байгаа будааг авах боломжгүй. Дээрээс нь тариаланчид будаагаа зарж чадахгүй, энэ жилийн тариалалтаа хийхэд эх үүсвэр дутмаг, зээлийн эх үүсвэр хүрэлцээгүй, тариалалт хийхэд хангалттай ийм нөөц хөрөнгө байхгүйн улмаас тариалалтад бас саатал учирч болзошгүй ийм байгаа юм. Тийм учраас энэ дээр зээлийн эх үүсвэрээр банкууд дээр байгаа боломжуудыг дайчилж гаргуулах, тэрэн дээр түрүүн Хүрэлбаатар даргын хэлсэнчлэн зээлийн хөнгөлөлтийг нь хөшүүрэг болгож олгох ийм схемээр л ажиллах юм байгаа юм. Яг тэр хэмжээг нь манайд судалгаан дээр байсан, та нар дээр тоонууд нь байна уу?

Ж.Ганбаатар: Ж.Бат-Эрдэнэ гишүүн, хариулт хангалтгүй гэсэн учраас 1 минут нэмж өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Хөдөө аж ахуйн яаман дээр байгаа үлдэгдэл будаа ямар хэмжээтэй, ямар чанартай будаа байгаа юм, тэрэн дээр дараа Их Хурал руу орж ирэхэд хариулт өгөөрэй. Нэг асуулт байна. Энэ гурилаа, будаагаа, махаа, шатахуунаа яг ямар үнэ дээр барих гэсэд байгаа юм, тийм зүйл байна уу? Одоогийн яг өнөөдрийн байгаа үнэ юм уу, эсвэл бас хэдэн сарын дараа болохоо байх нь гэсэд бас нэг үнэ дээр барих юм уу? Тийм үнэ дээрээ барья гэсэн зүйл байна уу?

Ж.Ганбаатар: Жавхлан сайд, гишүүний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Бат-Эрдэнэ ер нь голыг нь олоод асууж байна даа. Үнийг хатуу гаргахаасаа илүүтэй бид хүчтэй савлагаанаас зайлсхийж, аль болох тогтвортой байлгах ийм зорилго бол энэ хууль орж ирж байгаа юм байна. Үнэд маш олон зүйл хүчин нөлөөлж байгаа. Бидний ганц нөлөөлж чадахгүй зүйл бол гадна зах зээл дээрх үнэ. Хэлэлцээ хийлээ. Украин Орос хоёр орон хэлэлцээ хийлээ. Амжилттай боллоо, амжилтгүй боллоо гэсэд л та бүхэн харж байгаа байх. Ганцхан тэр мэдээнээс болоод маш хүчтэй савлаж байгаа юм. 138 бараг 140 хүрч байсан нь нэг өдөр 100-гаас доош орж байсан. Одоо 100-гаас 110, 120-ийн хооронд ингээд хэлбэлзэж байна. Бидний өнөөдөр хэрэглэж байгаа шатахуун жишээ нь энэ өнгөрсөн оны сүүлээр 80-аас доош байхад татсан шатахуунаа одоо бид нар хэрэглэж байгаа. Тэр нөөцөө хараахан дуусаагүй байгаа. Дараагийн татан авалтууд эхнээсээ гэрээнүүд нь хийгдчихсэн, 100 гаран доллар дээр гэрээнүүд нь хийгдсэн. Ингээд татан авалтууд орж ирэх гэж байна. Тэр үнэд бол бид нар шууд хүчтэй нөлөөлж чадахгүй.

Ж.Ганбаатар: Цогтгэрэл гишүүн асуулт асууя. Цогтгэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Цогтгэрэл: Яаралтай горимоор үнэ тогтворжуулах тухай хууль орж ирж байна л даа. Тэгэхээр эндээс яг одоо энэ хуулийг нь уншаад харахлаар яг яаралтай горимоор, тэгээд энийг хуулиар зохицуулах яг ямар хэрэгцээ шаардлагууд байгаа юм бол? Жишээ нь тэр хуулийн заалтуудыг харахаар яаралтай горимоор орж ирсэн хуулийг Их Хурал хэлэлцэнэ гэж байна. Энэ дээр нэг намын засаг, Их Хурал хоёр боломжтой. Засгийн газраас нөөц бүрдүүлнэ, татварын хувь хэмжээний асуудлыг өргөн барина гэж байна. Тэр чинь хэлэлцэгдээд явчих юм байна. Хүүгийн татаасын асуудлыг ерөнхийлөн захирагчийн дүн дотор өөрчлөн шилжүүлж болно гэж байна. Одоо энэ чинь КОВИД-ын хуулиараа боломжтой байгаа гэх мэтээр. Монголбанкны зүгээс ч гэсэн тэр, алт олборлогчдыг дэмжинэ, хөтөлбөр зарлана гээд. Энд яг хуулиар зохицуулахгүй бол болохоо байчхаад байгаа яг ямар зүйл байгаа юм? Бас нэг л зохицуулалтын арга хэрэгсэл, бичиг баримт л гарах асуудал болчхож байгаа юм биш үү?

Хоёрдугаарт нь, энэ явсаар явсаар, энийг харахаар баахан хөнгөлөлттэй зээл л олгох юм байна л даа. Дахиад л одоо бид нарын яриад байгаа нөгөө Хөгжлийн банк, ЖДҮ-ээс чинь, яг л энийг нэг давтчихсан хувилбар л гарч ирнэ шүү дээ. Хэн авсан, хэзээ авсан, зориулалт нь яасан, эргэн төлсөн үү гээд л. Тэгэхээр одоо энэн дээр Монголбанкнаас өмнөх засгийн үед хийгдэж байсан Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилтэд та нар энэ бодлого болоод энэ хэрэгжилтэд ямар дүгнэлттэй байдаг юм, эргэн төлөлт болоод зориулалт, зарцуулалт ямар байсан юм? Энэн дээр тийм мэдээ материал байдаг уу? Ямар дүгнэлттэй байдаг юм? Ерөөсөө л одоо энэ харахад Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг нэрийг нь өөрчлөөд орж ирж байгаа ийм л хэрэг л харагдаж байна л даа.

Дараа нь, ер нь энэ сая гурван бүтээгдэхүүний, мах гэдэг чинь өөрөө дотоодын зах зээлээс хамаарч байгаа. Тэр тусмаа одоо ингээд улс даяараа шүлхийдчихсэн. Нөгөө экспорт, гадагшаа гардаг хэмжээ дамжаа чинь энэ жил байтугай гурван жилдээ бараг гарахгүй. Тэгээд 60, 70 сая малыг 3 сая хүн идэхээр, энэн дээр чинь тийм нэг элдэв янзын бодлого гэхээсээ илүү тэр ханган нийлүүлэлтийг нь, бэлтгэн нийлүүлэлтийг нь, тээвэр ложистикийг нь, борлуулалтыг нь, одоо юу байдаг юм, шал өөр бодлого энэ дээр чинь нийлүүлэлтийг хэрхэн нэмэгдүүлэх юм гэдэг бодлогууд, үр тариан дээр ч гэсэн. Тэгэхээр заавал одоо энд нэг ингээд нэг санхүүгийн ялгаатай бодлого, хөнгөлөлттэй зээл, дахиад л өмнө нь гарсан нөгөө нэг алдаа, олон зүйлүүд, хэл ам, энийг дагаад баахан албан тушаалтнууд хэрэг төвөгт ордог энэ зүйл рүүгээ л энэ чинь явах гээд байгаа юм биш үү? Эдгээр дээр бас нэг тайлбар өгөөч ээ.

Ж.Ганбаатар: Жавхлан сайд гишүүний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Цогтгэрэл гишүүн таны асуултад хариулъя. Ийм шүү, бид онцгой цаг үед том сорилттой тулж дундуур нь явж байна. Аль нэг сурах бичиг дээр бичигдсэн онолын дагуу явдаг цаг үе ерөөсөө биш. Тэрүүгээр шийдэх ямар ч боломжтой асуудал энд байхгүй. Олон улсын геополитикийн асуудал ч тэр, эндээс орж ирж байгаа нөлөөллүүд ч тэр хаана ч байхгүй, хаана ч бичигдээгүй дүрмээр орж ирж байна. Ийм үед бас л бид ийм хариу арга хэмжээ авахаас өөр арга байхгүй. Энэ нөлөөллүүд орж ирж байна, бүх юм үнэ нэмэгдэж байна. Засгийн газар хариу арга хэмжээ авъя гэхээр болохгүй ээ, юу ч болохгүй, ингээд сууж бай гэж арай хэлэхгүй байх гэж бодож байна.

Хуулиар зохицуулагддаг арга хэмжээнүүд ч байна, зохицуулагдахгүй арга хэмжээнүүд ч энд олон байгаа. Өмнө нь гарч байсан, хэдийгээр санаа нь зөв боловч процедурын төрийн гаргах шийдвэрийн түвшин, ил тод байдал дээр алдаа гаргаж

байсан энэ зүйлүүдийг өнөөдрийн төрийн албан хаагч нар дээр тулгаж гаргах ёстой зөв зохистой шийдвэрийг нь гаргуулахгүй байх тэр байдал руу аваачиж болохгүй. Боломжуудыг нь өгөх ёстой. Бүх төрийн түвшний институцүүдэд, Төв банканд, Засгийн газарт ч тэр. Ийм зохицуулалтуудыг л энэ хуулиар хийж байгаа юм.

Та түрүүн мах ярьж байна. Махны хувьд бид хөдөө аж ахуйн орон, 60, 70 сая ийм малтай улс. Гэтэл энэ махны ханш маань яаж тогтдогийг та маш сайн мэднэ. 3.5 сая хүний амынх маань тал нь Улаанбаатар хотод байдаг. Тал нь бол хөдөө, орон нутагт амьдардаг. Тэгтэл махны үнэ яаж тогтдог вэ гэхээр Улаанбаатар хотоос сонгогдсон гишүүд хямдхан мах авахыг хичээдэг. Орон нутгаас сонгогдсон гишүүд үнэтэй мах Улаанбаатар руу нийлүүлэхийг хичээдэг. Энэ улс төрийн өрсөлдөөн дотор л энэ махны үнэ тогтдог шүү дээ. Үнэн биз дээ. Ийм гаж тогтолцоотой бид нар яваад ирчихсэн байхгүй юу. Сүүлийн 20, 30 жил Сонгуулийнхаа хуулийн гажгаас болоод ийм болоод ирчихсэн байгаа юм. Энэ бол зах зээлийн үнэ ерөөсөө огтоос биш.

Гэхдээ яг энэ үед, онцгой ийм хүнд үед монгол хүн махтайгаа, өргөн хэрэглээний бусад гурил, тэгээд шатахуун энэ зүйлүүдийг нь Засгийн газраас хийж хэрэгжүүлж чадах боломжит бүх аргаа хэрэгслүүд тогтвортой байлгая гэж л ингэж хичээж энэ хуулийг санаачилж оруулж ирж байгаа юм. Тийм тэрнээс биш ингээд л энийг задалж яриад л, дахиад л ЖДҮ, дахиад л Хөгжлийн банк гээд л ингээд яриад явах юм бол энэ арга хэмжээг хэн ч хэрэгжүүлж чадахгүй. Энийг зориглож хийх ямар ч төрийн инситуц гарч ирэхгүй. Эцэст нь олон нийт энэ үнийнхээ хөөргөдөл, энэндээ тэгээд л дарлагдах ийм байдал руу л аваачмааргүй байгаа юм.

Ж.Ганбаатар: Монголбанк гишүүний асуултад гүйцээгээд хариулъя. 5 номер, Лхагвасүрэн ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Үнэ тогтворжуулах хөтөлбөртэй холбоотойгоор Монголбанкнаас олон улсын ийм хөндлөнгийн аудитын компани дээр үнэлгээ хийлгэсэн байдаг. Хөндлөнгийн аудитын компанийн хийсэн үнэлгээгээр бол Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд ерөнхийдөө Монголбанк оролцсон. Төсвийн шинжтэй арга хэмжээ болсон байна гэж тухайн үедээ гарч байсан. Тийм үнэлгээ бол тэгж л харсан. Хөндлөнгийн л үнэлгээ.

Ж.Ганбаатар: Ерөнхий хариулж байгаа шүү. Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл: Саяын хоёр асуултад хоёуланд нь хариулт авсангүй дээ. Жавхлан сайдаас энэ хууль яг гарахгүй болохоор ямар заалтыг болохгүй болчхоод байгаа юм? Саяын энэ байгаа заалтууд чинь бүгдээрээ л одоо байгаа хуулийн хүрээнд засагт бол эрх нь өгөгдчихсөн заалтууд л байгаад байна л даа. Яг энэ заалт байхгүй болохоор Их Хурлаар шийдэхгүй бол болохгүй болчхоод байна гэдэг заалт харагдахгүй байгаа байхгүй юу.

Хоёрдугаарт нь, тэр Монголбанкнаас, ерөөсөө энэ ярьж байгаа зүйл чинь Үнэ тогтворжуулах хөтөлбөр л байна шүү дээ. Та нар тэгээд олон улсын аудит болоод өөрсдийн дүгнэлтээр энийг буруу бодлого байжээ гэж байгаа бол одоо яагаад энийг дэмжиж байгаа юм, гол нь?

Ж.Ганбаатар: Эхлээд Монголбанк хариулъя, гишүүний асуултад. 5 номер.

Б.Лхагвасүрэн: Тухайн үед, тухайн үеийн тэр Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгож байсан зээл нь бол зах зээлийн хүүнээс маш доогуур хүүтэй, нэгдүгээрт. “Сайн хувьцаа” ч юм уу, “Сайн хашаа” гэхэд бол дандаа 1 хувийн хүүтэй ийм зээлүүд

байсан. Тэр утгаараа энэ төсвийн шинжтэй арга хэмжээ байна гэж тэр олон улсын KPMG гэж хөндлөнгийн аудитын компани хийсэн байгаа. Өнөөдрийн энэ орж ирж байгаа хууль дотор байгаа зүйлүүд дотор бол тийм 1 хувийн хүүтэй хүү тогтоочихсон юм байхгүй, яг л зах зээлийн хүүтэй байна. Харин зах зээлийн хүүн дээр нь улсын төсвөөс тодорхой хэмжээний татаас, хөнгөлөлт үзүүлээд явна л гэсэн ийм заалт байгаа.

Ж.Ганбаатар: Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Түрүүн Цогтгэрэл гишүүний асуултад дутуу хариулчихсан байна шүү, уучлаарай. Их зөв өнцгөөс асуулаа. Ер нь бид нар дараа танилцуулга дээр яг тэр заалтуудыг, тэр зүйлүүдийг бол жагсаагаад танилцуулмаар юм байна шүү. Тухайлбал бид нар танд хуулиар зохицуулахаас өөр аргагүй гурван зүйлийг хэлье. Нэгдүгээрт, Төв банкны зүгээс энэ шатахуун импортлогч нарт тогтвортой валютын ханшаар шаардлагатай эх үүсвэрийг нийлүүлнэ гэж байгаа юм. Валютын эх үүсвэрийг. Тэрний нь төлбөр тооцоог нь хийх асуудал асуудлыг ч одоо Төв банк хариуцаад ингээд явах ёстой. Тэгвэл тэр сан, дериватив гэж ярьдаг mэр үүсмэл хэрэгслийг хэрэглэх тэр боломж эрхийг нь Мөв банканд өгч байгаа гэсэн үг, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Засгийн газрын баталгаа гэж байгаа юм. Зарим импортлогч нар банкны хязгаарлалт 20 хувьтай тулчихсан, нэмж эх үүсвэр зээл авах боломжгүй. Шатахуунаар татаж авах эх үүсвэр нь хүрэхгүй байгаа гэсэн үг. Урьд нь 10 төгрөгөөр жишээ нь 10 литр бензин татдаг байсан бол үнэ нэмэгдчихээр 10 төгрөгөөр нөгөө нөөцөө татаж чадахгүй болчхож байгаа юм. Тэгэхээр 12 төгрөг, 13 төгрөгийн хэрэгцээ гарна. Энэ зөрүүн дээр нь Засгийн газраас баталгаа гаргая гэж.

Ж.Ганбаатар: Жавхлан сайд, 2 минут сунгаж өгье.

Б.Жавхлан: Энийг энэ хуулиар ингээд бас хязгаарлалтыг нь тавьж өгч байна гэсэн үг.

Гуравдугаарт, татвар, гаалийн албан татвар. Энэ бол хуулиар зохицуулагддаг, өөрөөр хэлбэл Их Хурлаас зааж өгдөг ийм хуулийн зохицуулалттай. Тэрийг мөн энэ хуулиар зохицуулж байна гэж та хараарай. Дээрээс нь ФАТВ-ын хуультай холбоотой, тэр 20 сая төгрөг. 20 сая төгрөгтэй тэнцэх валют болон биет металлыг, 20 сая төгрөгөөс дээшихийг нь хилээр авч гарахыг хориглож байгаа. Энэ заалтыг хүмүүс нэг их анзаардаггүй байсан байх. Одоо жишээ нь 2 сарын 24-нөөс хойш өмнөх жилүүдтэй харьцуулах юм бол дунджаасаа нэлээд өндөр бэлэн валют гарч явсан байна. Гаалийн мэдээгээр авахад. Декларац дээрээ 1 сая доллар гэж тавиад 1 сая доллар аваад гарах манайх ийм хуулийн зохицуулалттай. Сүүлийн жишээнүүд сая гарсан тохиолдлуудыг харахад 1 сая долларыг арван хүнд хуваагаад 100, 100 мянган долларыг декларац дээр бичээд аваад явчхаж байна. Ийм үед бид нар ингэж валютаа алдах ямар шаардлага байна. Ямар ч хэрэггүй байхгүй юу. Энийг бид нар хуулиар зохицуулахаас өөр арга байхгүй, яаралтай горимоор шийдэхгүй бол болохгүй. Бид нар нэг өдөр, нэг доллар бид нарт хэрэгтэй байгаа учраас. Гадагшаагаа алдаж байгаа нэг доллар болгон эргээд бид нарт одоогоор 1.5 долларын ийм дарамт болж орж ирж байгаа юм. Гадаад валютын эх үүсвэр дээр. Иймэрхүү зүйлүүдийг Цогтгэрэл гишүүнээ хуулиар зохицуулж байгаа юм. Дараа танилцуулга дээрээ бид нар анхааралаад бүр ингээд жагсааж дурдъя.

Ж.Ганбаатар: Тэгээд жоохон оройтсон л доо. Зөндөө л ярьсан шүү дээ. Тэгээд тулчхаад, өөрөө асуудлыг бүр ийм цэгт оруулчхаад, тэгээд. Цэрэнпунцаг гишүүн асуулт асууя.

Ц.Цэрэнпунцаг: Эхлээд асуултаа асуучихъя дараа нь бас санал хэлчихье. Нэгдүгээрт, Монголбанкнаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ, Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ хоёр хоорондоо эвсэлдэж нэг нэгнийгээ дэмжсэн ийм бодлогууд байгаа байх л даа. Энэ хоорондоо олон заалтууд байна. Нэг заалт дээрээ бас Засгийн газраас хэрэгжүүлэх арга хэмжээ нь энэ Монголбанкнаасаа хэрэгжүүлэх арга хэмжээгээ дэмжсэн ийм юм харагдахгүй байх юм.

Алт олборлогч, аж ахуйн нэгжүүд эргэлтийн хөрөнгийн болон урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг олгоно гээд алтаа авах энэ бодлогоо дэмжихийн тулд Монголбанкнаас арга хэмжээ авах нь. Тэгэхээр Жавхлан сайдаа Засгийн газраасаа алт олборлогчдоо, алт олборлох гээд янз бүрийн зөвшөөрөл, лиценз, тэгээд л олон хүнд сурталтай холбоотойгоор гацсан төслүүдээ яаралтай явуулахын тулд, энэ дээр нь бас заалт зүйлд оруулаад өгвөл болдоггүй юм уу? Тэгээд бид нар чинь хамгийн гол нь гадаад зах зээлээс алт авахаасаа илүү дотоод зах зээлд нийлүүлж байгаа олборлогчдоо дэмжих нь хамгийн гол бидний зорилт байх ёстой шүү дээ. Тэгэхээр энэ алт олборлогчдоо дэмжсэн зүйл заалтыг Засгийн газраас хэрэгжүүлэх арга хэмжээн дотроо оруулчихмаар санагдах юм. Миний асуух гэсэн асуулт бол ерөөсөө энэ. Энэ дээр Засгийн газрын хийх ажил дээр энийг оруулъя гэсэн саналтай байна. Энийг болох уу, үгүй юу? Жавхлан сайд та хариулж өгөөрэй.

Тэгээд санал хэлчихэд одоо бид нарын энэ өнөөдрийн яриад сууж байгаа юм бол ерөөсөө л бид нар экспорт хийж чадахгүй, нөгөө валют байхгүй болчихоод л, энэнээс үүдэлтэй болоод л ингээд л суугаа шүү дээ, тийм ээ? Бид нар хангалттай валюттай байсан бол, тэгээд л тэр ховордож байгаа юм нь мэдээж үнэтэй болно. Үнэтэй юмыг нь авчраад л хэрэглээд л явна, асуудал байхгүй. Өнөөдөр бол хамгийн гол асуудал юунаас босож ирж байна вэ, бид нарт байдаг нөгөө ногоон /доллар/ байхгүй. Тэгээд энэ асуудал ерөөсөө л зөвхөн өнөөдөр бид нараас үл хамаарах энэ гаднын нөхцөл байдлаас хамааraад л ийм хүндрэл гарч ирээд, ийм юм яригдаад байж байна л даа. Тэгэхээр энэ бол зөвхөн өнөөдрийн нэг Засгийн газар, хоёр Засгийн газар биш, сүүлийн 30 жил бид нар энэ чөлөөт зах зээл, энэ чөлөөт нийгмийг сонгосон сүүлийн 30 гаран жилд л бид нарын явж ирүүлсэн бодлого буруу байгаагийн л нэг үр дүн шүү дээ.

Буруу явсных, тэрний үр уршиг л ингээд л, нэг ийм далд өвчин явж байгаад л, тэгээд л нэг жоохон гадаа нөхцөлд нөхцөл бүрдэхээр зэрэг өвчин хүндрээд л гараад ирдэг шиг л ингээд л гарч ирээд байгаа байхгүй юу. Сая КОВИД-оор гарч ирсэн, одоо энэ гадаад нөхцөл байдал, энэ цэрэг дайны асуудлаас болоод л ийм асуудал гараад ирлээ. Тэгэхээр түрүүн зарим гишүүд маань яриад л байгаа юм. Тэгээд л бид нар дэлхийн зах зээлээс өөрийгөө тасалж яваад л дотоодынхоо үйлдвэрлэлийг дэмжих, ийм л үндэсний үйлдвэрлэлээ дэмжих гэсэн ийм л бодлого байх ёстой. Тэгээд хамгаалалтыг бол одоо тариф, гаалийн тарифаа, импортын татвараа нэм, ингэж л хамгаалах ёстой л гээд байгаа юм. Энийг бол одоо бид нар бодлого болгож ингэж их өөгшүүлж яримааргүй байгаа юм.

Бид нар чинь одоо дэлхийн том зах зээл дээр энэ нийлүүлэгч нийлүүлж байгаа энэ олон төрлийн энэ барааг чинь хямдхан авбал бид нар, ард түмэн л хожиж байгаа шүү дээ. Өнөөдөр дандаа ийм асуудал орж ирнэ. Энэ бол ерөөсөө хэдхэн л төрлийн цөөхөн төрлийн бизнес. Нэг ийм бүлэг бизнес нэг салбарыг ч юм уу, онцгой ингээд л дэмжих юм бол бид нар хэн, хэний тэд нарын салбарыг дэмжсэний тэр дэмжлэг дэмжлэг, тэр татаас ямар нэгэн илбэ биш гэхэд ямар нэгэн хэлбэрээр хэн төлөх юм гэхээр нийт ард түмэн, энэ гурил иддэг, мах иддэг, бензин шатаадаг бүгд энийг чинь.

Ж.Ганбаатар: Цэрэнпунцаг гишүүнд 1 минут.

Ц.Цэрэнпунцаг: Тэгээд ер нь зүгээр нэг иймэрхүү яриа юунууд их явдаг болчихсон юм шиг байна аа. Хамгийн гол нь бид нар өнөөдрийн нөхцөл байдал бол гадаадын хөрөнгө оруулагчдаа хөөгөөд явуулчихдаг, тэгээд энэ хөрөнгө оруулалт оруулж ирээд, хувийн хэвшлийнхэн маань янз бүрийн төсөл хөтөлбөр, бизнес эрхлээд явуулахаар ялангуяа сүүлийн үед бол энэ уул уурхайтай холбоотой, ялангуяа алт олборлогчдоо бол нүд үзүүрлэсээр байгаад бүгд байхгүй болж байна шүү дээ. Тэгээд өнөөдөр алт үнэтэй боллоо гээд одоо нөгөөдөхөө яаж олж авах вэ, яаж худалдаж авах вэ гэвэл яриа үүсгэж байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо энэ нэг захиргааны аргаар ингээд зогсоочихсон, улс төржүүлээд зогсоочихсон, ялангуяа энэ попордог поп улс төрчид бол ярьсаар байгаад бүгдийг нь хөөгөөд явуулдаг ажлыг нь зогсоодог шүү дээ. Энэнээс болоод зогсчихсон энэ том төслүүдийг хөдөлгөх хэрэгтэй. Тэгэхгүй бол одоо бүгд тэр төмөр зам барьж байсныг нь зогсоочихно, том алт олборлолт эхлээд явуулах гэж байсан аж ахуйн нэгжүүдийг.

Ж.Ганбаатар: Гишүүний асуултад хариулъя. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Цэрэнпунцаг гишүүний тэр алтан дээр бол ийм юм байна аа, бид нар бас нэлээн судаллаа. Бид нар бол маш либерал юм байна шүү дээ, алтан дээр. Ялангуяа үйлдвэрлэл дээр нь бол манай улс шиг ингэж үйлдвэрлэлийг нь дэмждэг, Төв банкан дээрээ маш нээлттэй, харьцангуй, одоо юу гэх юм бэ дээ, их хөнгөлөлттэй, ээлтэй байдлаар их худалдаж авдаг. Би ганцхан жишээ хэлье. Ашигт малтмал дээр уулын тайлан дээр нийт олборлолтын бараг 80, 90 хувь нь аж ахуйн нэгжүүд байдаг. Гэтэл Монголбанкан дээр алт тушааж байгаа хэлбэрийг нь харах юм бол 70 хувь нь иргэд тушаадаг. Гэтэл тэрэн дээр бид нар ямар ч хориглолт тавьдаггүй. Тэр нь бол чөлөөтэй, маш либерал ингээд явж байдаг. Үйлдвэрлэл дээр нь хөнгөлөлттэй зээлээр маш хангалттай өгч байгаа юм. Банкнуудаар дамжаад л яг бизнесийн зарчмаараа банкныхаа шаардлагыг хангаад авч чадах үйлдвэрлэл, алтны лиценз дээр бол хангалттай зээлийн эх үүсвэрүүд өгч байгаа. Нэг л зүйл байдаг юм байна лээ. Ерөөсөө л байгаль орчны асуудал. Нөгөө урт нь нэртэй хууль дотор чинь одоо бараг 6-10 тонн алт тэнд хадгалаастай байгаа юм. Тэрийгээ бид нар гаргаж ирж авч чадахгүй байгаа ийм л асуудал юм байна лээ.

Тэгэхээр тэр хөшүүргийг бид татварын бодлогоор юм уу, бусад, төрийн бодлогоор ард түмэнд, орон нутагт нь илүү ээлтэй. тэр хүмүүс орон нутгийнхан бараг алтны үйлдвэрлэлийнхнийг урьж авчраад тэнд нь алтны үйлдвэрлэлийг явуулаад авах юмаа аваад, шаардлагаа тавиад нөхөн сэргээлтийг нь ном журмынх нь дагуу стандартынх нь дагуу хийлгэж байдаг тэр хэлбэр лүүгээ л бид бодлогын шилжилтүүд хийх ёстой. Энэ дээр харин их том улс төрийн зориг гаргаж бид шийдэл гаргах ёстой шүү гэж хэлмээр байна. Энэ дээр та бүхнийг сайн дэмжээрэй, бид нар бас энэ тал руу нь явуулна гэж ингэж харж байгаа.

Энэ удаагийн хуулиар орж ирж байгаа зүйл бол богино хугацаанд нэг удаагийн арга хэмжээнүүд шүү. Зөвхөн энэ жил. Үйлдвэрлэл гэхээр энэ чинь хойтон үр дүн нь гарна, хоёр, гурван жилийн асуудал болоод явчихна. Одоо ингээд л хуульдаа өөрчлөлт оруулна, энэ тэр гээд. Одоо олборлочихсон байж болзошгүй далд энэ алтнуудыг л Төв банкан дээр авчирч тушаалгах яаралтай арга хэмжээнүүдийг л авах гээд байгаа юм. Тийм хөшүүрэг дээр л тэр 5 хувь гэж ярьж байгаа байхгүй юу. 5 хувь гэдэг маань рояалттайгаа тэнцэх, тэрийг тэглэх хэмжээний л перемен тавьж алт тушаалтыг урамшуулъя гэж байгаа юм. Мөн энэ дээр бас бид татварын өршөөл энэ тэрийг бас харж судалсан л даа. Тэгэхдээ үнэхээр тэр далд алт нь үнэхээр тийм их хэмжээний байгаа ч уу, үгүй ч үгүй, сайн бид нар харж чадахгүй байна. Тийм бага хэмжээний зүйл байдаг бол тэрний төлөө том татварынхаа тогтолцоог эвдэх хэрэг ч

байна уу, үгүй юу гээд. Энэ удаа бол ямар ч байсан энэ нэг ийм худалдан авалт дээр нь ийм перемен тавиад үзье гэсэн ийм шийдлээр оруулж ирж байгаа юм.

Ж.Ганбаатар: Ганибал гишүүн асуулт асууя.

Н.Ганибал: Энэ хууль орж ирэхээсээ эхлээд л нэг сонин л орж ирээд байна л даа. Уг нь бүлгийн хурлуудаараа хэлэлцэгдээд Ардын намын бүлгийн гишүүд маань энэ хуулиа хэлэлцчихээд нэгдсэн нэг байр суурьтай болоод өнөөдөр орж ирээд хэлэлцэгдсэн бол бас энэ нэг журмын дагуу явах байх. Сая Байнгын хорооны хуралд суухын өмнө Засгийн газрын тэргүүн сайд нартайгаа сууж байгаад хэвлэлийн бага хурал хийж байна лээ. Мэдэгдэл, одоо хэвлэлийнхэнтэй уулзаж байгаа юм уу. Би шалтгааныг нь юу гэж ойлгосон бэ гэхээр хэд хэдэн ноцтой асуудлууд ярьж байсан. Юу гэсэн бэ гэхээр энэ асуудлыг хэлэлцүүлэхэд Улсын Их Хурлын хэсэг бүлэг гишүүд эсэргүүцэж байгаа гэж байна лээ.

Дээрээс нь аливаа асуудлыг оруулж ирэнгүүт бас нэг бүлэглэлүүд гээд бас тэд нар нь мөнгө өгөөд Их Хурлын гишүүдийг удирдаад кноп даруулдаг ийм асуудлаас болоод бид нар ард түмнээсээ болон хэвлэлийнхнээсээ тусламж гуйхаар та бүхэндээ хандаж байна гэсэн иймэрхүү ойлголтууд сонсогдсон. Энэ яагаад өнөөдрийн энэ хууль бүлгийнхээ гишүүдээр орохгүйгээр, хэвлэлийнхэн болон ард түмэнд хандаж байгаад энэ хуулийг оруулж яаралтайгаар оруулж ирж байгаа юм бэ гэдэг энэ асуудлууд нэлээн ноцтой юм уу даа гэж бодсон.

Энэ асуудлуудыг ингээд харахаар сая гишүүд маань ер нь маш тодорхой л ярьж л байна л даа. Мөнгө хэвлэх нь тодорхой юм байна. Цаашлаад үнийг барихын тулд тогтвортой нэг үнэ дээр аваачих юм байна гэсэн. Махны асуудал дээр та бүхэн маань ямар нэгэн судалгаа хийсэн юм уу? Өнөөдөр Монгол Улсын бүх зооринуудад адууны цул махнууд байна, үхрийн болон хонины мах нийтдээ 50 орчим мянган тонн мах байгаа. Энэ мах өнөөдөр зах зээл дээрээ гарахаа хүлээгээд байж байгаа. Засгийн газар өнгөрсөн жил махны үнийг тогтворжуулна гэсэн нөөцөөр 7-гоос хэдэн мянган тонн ч билээ мах авсан. Ингээд тэр махнууд нь зах зээл дээр гараад эхэлчихсэн. Өнөөдөр бид нар тогтвор үнэ тогтворжуулах ийм мөнгө зах зээл дээр гаргаад тэрийг хэнд өгөх гээд байгаа юм? Махны үйлдвэрүүдэд өгөх өгөөд тэр яах юм, мах нь байгаа тэрийгээ зарна л биз. Харин малчид маань тэр махаа, одоо үйлдвэрлэгч нь малчид шүү дээ.

Магадгүй 2012-2013, 14 онд болж байсан махны үнэ тогтворжуулахтай харьцуулж яриад байна л даа. Тэр чинь зорилго нь өөрөө байсан юм аа. Хавар махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх ийм бодитой ажлууд хийсэн, зооринуудыг өнөөдрийн түвшинд авчирсан юм. Мах хадгалах зоорь байхгүй байсан. Тэрийг өнөөдрийн түвшинд авчирсан. Өнөөдөр хавар нойтон мах нийлүүлдэг томоохон фермүүд байхгүй байсан. Энэнд зориулаад гаднаас 2000-3000 үхрийг оруулж ирсэн юм. Ингээд энэ үйлдвэр юу эрчимжсэн аж ахуйнуудыг бий болгосон. Одоо энэ дээр тахиа, гахай бүгд дээр нь энэ арга хэмжээнүүдийг авсан байгаа. Харамсалтай нь өнөөдрийн энэ хууль дээр бичсэн энэ махны үнийг тогтворжуулах асуудал нь зүгээр л нэг өгүүлбэр бичээд оруулаад ирсэн, ямар ч судалгаагүй ийм л юм уу гэж харагдаад байх юм. Хаана байгаа махыг яаж гаргах гэж байгаа юм гэдгээ. Уг нь байсан бол Хүнс, хөдөө аж ахуйн сайд маань энэ судалгаануудаа маш сайн гаргаж ирээд тайлбарлах байсан байлгүй дээ.

Сүүлийн үед махан дээр гарч байгаа статистикийн тоон мэдээллүүдийг олж харахад 2020, 2021 онд 450 мянган тонн мах Монгол Улс бэлдсэн гэнэ ээ. Тэгээд 30 мянган тонн мах экспортод гаргасан гэж байгаа юм. Монгол Улсын нийт хэрэглээ 180-200 мянган тонн мах, цаана нь үлдсэн 200 мянган тонн нь хаана байгаа юм? Ямар нэгэн гааль мэдүүлэхгүйгээр гараад байгаа юм уу, эсвэл энэ статистик чинь худлаа

яваад байгаа юм уу? Энэ бүх боломжуудаа та бүхэн бас нарийн судлаад энэ хуульдаа оруулж ирмээр байна. Өнөөдөр бид нар яг үнэхээр нефтийнхээ үнийг.

Ж.Ганбаатар: Дараа нь тодруулах уу? Жавхлан гишүүн асуултад хариулъя.

Б.Жавхлан: Энэ мах бэлтгэн нийлүүлэх, мах борлуулалт, түгээлт хэрэглэгчид гээд энэ том тогтолцоог ер нь дампуууруулаад хаячихсан шүү дээ. Тэр олон жил дампуууруулж хаясны чинь үр, горыг нь бид нар өнөөдөр маш үнэтэй төлж байгаа л ийм л асуудал юм байгаа. Богино хугацааны шийдэл ярьж байгаа л ийм л ийм зүйл юм байгаа юм. Тэр үе үеийн Засгийн газрын тогтолцоо, тэр зоорьтой холбоотой юм ярих юм бол дампуур юм их байгаа шүү.

Дээрээс нь таны хэлэх гээд байгаагийн санааг ойлгож байна. Орон нутгийн гишүүд маань, одоо жишээ нь Сүхбаатар аймгийн тойргоос сонгогдсон гишүүн боловч та Монгол Улсын Их Хурлын гишүүн. Махны хувьд Монгол Улсын нийт мах хэрэглэгчдийн эрх ашгийн үүднээс энд хандах ёстой шүү гэдгийг танаас хүсэж, уриалж байна. Онцгой үед бид нар богино хугацаанд авах арга хэмжээний талаар л бид нар ярьж байгаа юм. Тэрнээс биш тэр бэлтгэн нийлүүлэх үйлдвэрлэлийн тогтолцооны асуудлыг ер нь хуулиар зохицуулах зүйл байхгүй, шаардлагагүй. Тэгж энэ хуулиар амжих ч үгүй юм байгаа юм. Баярлалаа.

Ж.Ганбаатар: Ганибал гишүүн тодруулъя.

Н.Ганибал: Ер нь тэгэхдээ жоохон цэгээ олж довтолмоор байна. Өнөөдөр бид нар өргөн хэрэглээний бүтээгдэхүүн бүгдээрээ үнэ өсөж байгаа, импортын маань тодорхой хэмжээний тээвэрлэлт болон хил гаалийн хязгаартай байгаа. Бид нар дотоодынхоо хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгаа. Энэний экспорт дээр та бүхэн бас энэ хуульд оруулж ирээч ээ. Дотоодын хэрэглээнд оруулж ирж байгаа үндэсний үйлдвэрлэгч нар маань үйлдвэрлэж чадахгүй тэр бүтээгдэхүүний экспортыг нь бас хааж өгөөч гэж бас хүсмээр байна. Тэрнээс, дотооддоо хэрэглэж байгаа складууд дүүрэн байгаа тэр бүтээгдэхүүнийг экспортод гаргах асуудлыг та нар бодож олж өгөөч ээ.

Өнөөдөр Оросын Холбооны Улс руу манай бизнесменүүд жонш гаргаад түүндээ бартераар арматур авах энэ асуудлыг судлаад хөөцөлдөөд явж байгаа. Энэ дээр жишээлбэл, Засгийн газар.

Ж.Ганбаатар: Жавхлан сайд хариулъя. Жавхлан сайдын микрофоныг 2 минутаар.

Б.Жавхлан: Энэ хууль дээр тийм зүйл хөндөхгүй ээ. Тэр бол яг бусад салбарын хуулиар хөндөнө. Дээрээс нь нөгөө улс төрийн холбогдолтой асуулт хөндсөн, бүлгээрээ орсон юм уу, ярьсан юм уу гээд. Өчигдөр Даваа гарагт болсон ээлжит бүлгийн хурлаар Засгийн газар энэ асуудлаа оруулсан танилцуулсан. Бүлэг дээрээ энийг хэлэлцээд улс төрийн дэмжлэг үзүүлнэ, энэ хуулийг явуулах нь зүйтэй, Улсын Их Хурал дээр дэмжинэ гээд ингээд оруулж ирсэн юм байгаа юм шүү.

Өнөөдөр бол одоо ингээд Байнгын хорооны түвшинд, ажил хэргийн түвшинд ингэж задлаад ярих нь бол энэ бол эрүүл мэтгэлцээн гэж ингэж бодож байна. Хэлэлцэх ёстой ийм зүйлүүдээ хөндөж ярьж байна гэж бодож байна.

Ж.Ганбаатар: Өчигдөр бас бүлгээр орсон байгаа. Доржханд гишүүн асуулт асууя.

Т.Доржханд: Парламент дээр ярьж байгаа нь бол зөв өө, зөв. Тэгээд Сангийн сайдын хэлж байгаа энэ эрүүл мэтгэлцээн гэдэг дээр та харин байр сууриа яг хатуу байгаарай. Би маш тодорхой зүйл асууна. Асуухаасаа өмнө бас байр сууриа нэг илэрхийлчихье.

2016, 2020 онд Монгол Ардын Нам ялсан. Яагаад ялсан юм? Яагаад вэ гэхээр 2012-2016 оны эдийн засгийн бодлого болохгүй байсан. Буруу байсан. Үнэ тогтворжуулах хөтөлбөр, дөрөв, таван төсөвтэй. Мөн биз? Үнэн байхгүй юу. Тэгсэн, өнөөдөр яахаараа тэр буруу бодлогыг, Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хийнэ гээд орж ирж байгаа юм бэ? Одоо энэ Хүрэлбаатар гишүүнээс авахуулаад л бүгдээрээ буруу зөрүү байсан гээд л. Ард тал нь та нар зогсож байгаад л 2016, 2020 онд ялаа биз дээ? Тэгээд одоо яагаад энийгээ хийж байгаа юм? Энэ дээр тодорхой хариулт өгмөөр байна.

Хоёрдугаарт, төсөв хэлэлцэж байх үед Сангийн сайд аа, би танаас бас тодорхой асуусан. Бас өөрийнхөө саналыг хэлж байсан. Олон улсын эдийн засгийн нөхцөл байдал хэцүү. Таны төсвийн төсөөлөл чинь хэтэрхий өөдрөг байна, орлогын төсөөлөл чинь. Үр дүнд нь та арван наймаар задлаад тэлчихлээ. Та энийгээ яг орлого нь орно гэж тооцож байна уу? Та энэ дээрээ хариуцлага хүлээх үү гэж асуусан. Та тов тодорхой, энэ бол ийм байна, би бол хариуцлага хүлээнэ гэсэн, тийм биз?

Гэтэл өнөөдөр орж ирж байгаа нөхцөл байдал чинь өөрөө эдийн засаг маш хүнд байгаа. Зөвхөн та бид хоёр ч хэлэлцгүй гудамжинд байгаа, зүгээр амьдарч байгаа хүн болгон мэдэж байна. Долларoо ч авч чадахгүй, буцаад талхаа зүсэж авдаг болчихлоо. Тэгэхээр ийм байна, нөхцөл байдал. Өөрөөр хэлэх юм бол сэрэмжлүүлээд байхад болно гэж орж ирсэн. Одоо тулгаад нэг гал унтраах байдлаар явдаг. Асуудал үүслээ гэвэл КОВИД руу заадаг. Одоо ингээд дайн луу зааж байна л даа. Тэгэхдээ онцгой нөхцөл байдал гэсэн. Ийм тайлбар хийгээд байх шиг байна. Энэ бол буруу. Яагаад вэ гэхээр өмнө нь энийг асуудлыг зөндөө сөхөж ярьж байсан. Тэгэхлээр энэ дээр ямар хариуцлагын асуудал байна, та хэлсэн үг үгэндээ байх уу?

Гуравдугаарт, одоо асуулт асууя. Яг нийт ямар хэмжээний санхүүжилтийн асуудал ярьж байгаа юм бэ? Өмнө нь бол 6 их наядаа сайхан цацаад хаячихсан, 3 хувийн хүүтэй зээл аваад, тэрийгээ доллар болгоод мөнгө хүүлж байсан нөхдүүд ч зөндөө байгаа шүү дээ. Тэгээд эрх мэдэлтэй нөхдүүдэд нууцаар өгчихдөг, жирийн хүмүүс бол авч чадаагүй шүү дээ. Тэгээд одоо бол ингээд гурван салбарыг онцлоод байх шиг байна. Тэгэхээр ямар хэмжээний мөнгө яригдаад байна?

6.1.5-д болохоор энэ хуулийг хэрэгжүүлснээр Монголбанкны пассив нь актив хөрөнгөөс хэтэрсэн тохиолдолд үнэт цас гарах замаар уг зөрүүг нөхнө гэж байна. Төв банк үнэ цаас гаргах юм уу? Одоо инфляц чинь 15 хувьтай байгаа, ханшаа алдчихсан байгаа ийм тохиолдолд Төв банкны үнэт цаасыг хэн авах билээ. Тэгэхээр та нар хэдэн хувьтай гаргах юм, яаж хардаж байгаа юм? Энэ дээрээ тодорхой хариулт өгөөрэй.

Монголбанкны удирдлагад хариуцлага тооцох асуудлыг ярьсан. Гэтэл өнөөдөр Монгол Улсын Ерөнхий сайд нь би өөрөө энийгээ хамгаална гэж ярьж байх шиг байна. Энэ би буруу гэж бодож байна. Яагаад вэ гэхээр Үнэ тогтворжиж болох хөтөлбөрийг ярьж байх үед Алтанхуягийн Засгийн газар, Алтанхуяг гэдэг хүн бол хажуу талдаа Золжаргал гэдэг хүнийг өвөртлөөд ингээд Төв банкны хараат бус байдал байхгүй болсон. Үр дүнд нь бид нар эдийн засгаас самруулсан. Гэтэл өнөөдөр Монгол Улсын Ерөнхий сайд нь бол би өөрийнхөө хэмжээнд, өөрөө ямар ч байсан Монголбанкны Ерөнхийлөгчөө хамгаална гэнгүүт Монголбанкны Ерөнхийлөгч нь яг энэ алдааг давтаад орж ирж байна уу гэж харагдаад байна.

Ийм болохоор, үгүй ээ, энэ чинь ёс зүй байх ёстой, хууль байх ёстой, хараат бус байх ёстой. Та одоо Ерөнхий сайдаар хамгаалдаг ийм хуультай болчихсон юм уу? Ерөнхий сайд нь Төв банкныхаа удирдлагыг хамгаалдаг болчихсон юм уу? Яаж хамгаалах юм, хуулийн орчин нь юу байгаа юм. Энийг би Засгийн газраас нь бас асуучихмаар байгаа юм. Харин тэр арван жилийн хугацаанд төмөр замыг гацаасан бүлэглэл байсан гэдэгтэй бол би Ерөнхий сайдтай санал нийлж байгаа шүү.

Ж.Ганбаатар: Хэн хариулах вэ? Жавхлан сайд гишүүний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Доржханд гишүүний асуултад хариулъя. 2012-2016 онд Үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлсэн. Тэрнээс улбаатай янз бүрийн л улс төр, буруу зөрүү юмнууд олон их явж байгаа. Одоо ч дуусаагүй юмнууд ингээд явж байгаа юм.

Энэ удаагийн нөхцөл байдал бол бид нар бас шинээр ажиллах, хурдтай ажиллах, хуулийн орчинд ил тод ажиллах ийм нөхцөл байдлыг шаардаж байгаа юм. Бид нар яг энэ хүрээнд ажиллаж байгаа. Өмнө нь хэрэгжүүлж байсан арга хэмжээнүүдээс өөр. Их Хурал дээр бид энэ асуудлыг шийднэ. Дээрээс нь ямар нэг байдлаар Монголбанк Засгийн газарт, Засгийн газар нь Монголбанканд бодлогын ёс зүйгээ, бодлогоор хамгаалагдсан өөрсдийн бие даасан хараат бус байдлыг нь, тэр алтан зураасыг нь давсан улс төрийн шахаа үзүүлж, ийм макро баланс алдагдуулах тийм байдалд хүргэхгүй. Тэрийг нь хуулиар маш тодорхой зааж байгаа. Та энэ хуультай маш сайн танилцаарай, уншаарай, үзээрэй. Ийм байгаа юм.

Дээрээс нь тэр орлоготой холбоотой асуулт байна. Доржханд, гишүүн ээ, хэрвээ та надад хариуцлага тооцмоор байвал, хэрвээ одоо ингээд хариуцлага тооцоод бүх юм сайхан болчихдог бол би одоо ч хариулахад бэлэн байна. Та битгий санаа зовоорой, энэ дээр. Бид өнгөрсөн оны гурав, дөрөвдүгээр улиралд энэ оны төсвийг бид хэлэлцэж байхад дэлхий нийтээрээ 2022 оны эдийн засгийн өсөлтийг өөдрөг төсөөлж байсан. Энэ дайн бүхий байдал үүснэ гэдгийг та хэлж байсан гэж би санахгүй байна. Ер нь бол эрсдэлтэй байх талаас нь бид бодолгүй л яах вэ. Гэхдээ бид 2020, 2021 оны КОВИД-ын үеийн энэ цохилтыг бид эдийн засгийн өсөлт, эдийн засгийн тэлэлт дээр тулгал зорилго тавьж байж тэрний хойноосоо явж байж л бид нар эдийн засгийнхаа өсөлтийг хангана, эдийн засагт оролцогч нарын хүлээлтийг зөв явуулж бид нар удирдана. Тийм төсөөлөл, тийм суурин дээр бид нарын хийсэн ийм төсвийн бодлого байгаа.

Мэдээж энэ жилийн төсвийн хэрэгжилт, гүйцэтгэл, төсвийн орлогоос шууд хамаарна. Орлого тал дээр бид тодорхойгүй байдлууд үүсэж байна. Гэхдээ бид Төсвийн хууль болон бусад Төсвийн тогтвортой байдлын хуулийн шаардлагынхаа хүрээнд бодлогын зохицуулалтуудаа хийгээд явна. Шууд нөлөөлөх зүйл бол энэ Төв банкнаас мөнгөний бодлогын хатуу төлөв рүү шилжсэн энэ байдал төсөв рүү шууд нөлөөлнө. Эдийн засгийн идэвхжлийг тодорхой хэмжээнд сааруулна. Энэ дайн бүхий байдал, зэвсэгт мөргөлдөөний нөлөөллүүд шууд бус биш шүү. Бүр шууд замаар нөлөөлж байгаа энэ байдлууд бидэнд бол нөлөөлнө. Ингээд тохиргоонуудаа хийгээд явна. Бидэнд хууль байдаг, хуулийнхаа хүрээнд тохироонуудаа хийгээд явна.

Тэр санхүүжилтийг би дахиад хэлье. Түрүүн Төв банкны ерөнхийлөгч ч хэлчихсэн. Төсвөөс гаргах эх үүсвэр, мөн Төв банкнаас мөнгө хэвлэж гаргах эх үүсвэр шаардлагагүй болов уу гэж ингэж харж байгаа юм. Тийм зохицуулалт хийгдэхгүй. Өмнөх үнэ тогтворжуулахаас ялгаатай нь энэ. Ингэж явна. Актив, пасивын зөрүү гэж байгаа. Энэ бол та мэдэх байх. Төв банкны хууль дээр байдаг заалт шүү дээ. Төв банкны хууль дээр байдаг заалтыг Төв банкныхан хүсэлт тавьсан. Энэ хууль дээрээ дахиж сануулж, тодруулж оруулж өгөөч гэж. Тэр хуулийг л дахиад сануулаад тавьчихсан байгаа л заалт юм байгаа юм. Энэ шинэ заалт өмнөх өөр хуулиуд дээр

давсан тийм заалт биш. Яг ийм заалт Төв банкны хууль дээр байдаг. Шаардлагатай бол хэрэглэдэг. Тэгэхдээ 1990 оноос хойш Төв банкны хууль гарснаас хойш энэ заалтыг ганц ч удаа хэрэглээгүй юм байна лээ.

Ж.Ганбаатар: Монголбанк гишүүний асуултад хариулъя. 2 минут, 5 номер.

Б.Лхагвасүрэн: Доржханд гишүүний асуултад хариулъя. Тэгээд Жавхлан сайд бас нэлээн тодорхой хэлчихлээ. Ерөнхийдөө энэ дээр бол Төв банкны зүгээс бол шинээр мөнгө одоо хэвлэнэ гэж яриад байгаа юм, мөнгө нийлүүлээд оролцох юм байхгүй. Ерөнхийдөө бол 2021 оноос хойш, ялангуяа тэр КОВИД-ын нөхцөл байдлаас болоод Хятадын хил хаагдсан. Энэнээс болоод экспорт бол маш их хэмжээгээр бууraад явж байгаа. Ингээд эдийн засаг бол өөрөө энэ төвөгтэй нөхцөл байгаа учраас Төв банкны зүгээс аль болохоор эдийн засгийг хэвийн хэмжээнд нь хадгалах л ийм бодлого явж байгаа. Тэгэхээр бол шинээр мөнгө хэвлэнэ гэдгээсээ илүү зах зээл дээр нэгэнт байгаа мөнгийг харин эдийн засгийн эргэлтэд оруулна гэдгээрээ л Монголбанкны оролцоо нь энд байж байгаа юм.

Т.Доржханд: Үнэт цаасны талаар?

Б.Лхагвасүрэн: Сая Жавхлан сайд хариулсан. Энэ дээр Төв банкны үнэт цаасны тухай биш ээ. Энэ өөрөө Төв банкны тухай хууль дээр байдаг. Хэрвээ Монголбанк зах зээлийн ханшаас арай илүү урамшуулалтай буюу тэр 5 хувийн нэмэгдэлтэй алт авбал энэ нь олон улсын нягтлан бодох бүртгэлийнхээ тэр зарчмын дагуу зардал болоод бичигдэнэ. Тэгэхээр актив, пасив бол зөрнө л гэсэн үг.

Ж.Ганбаатар: Доржханд гишүүн тодруулъя.

Т.Доржханд: Жавхлан сайд аа, КОВИД-ын нөхцөл байдлаас хамааraад эдийн засаг чинь хүндрээд байгаа юм уу, дайнаас болоод байгаа юм уу гэдгээ ялгаарай. Эдийн засагчид бол гол нь экспортын орлого орох урсгал байхгүй дээ. Дээр нь бол урд хөршийн хил хаалттайгаас л гэж харж байгаа шүү. Өөрөөр хэлэх юм бол өнөөдөр илүү нөлөөлөл нь болохоор урд хөршөөс, КОВИД-оос. Чуулганы үеэр бол КОВИД-ын хүндрэл байна гэж ярьсан. Үнэн, гэхдээ дайны асуудал руу бол чиглэж болохгүй ээ.

Тэгээд одоо асууя. Та ингээд Монголбанк мөнгө хэвлэхгүй л гээд байна. Тэгвэл энэ тавдугаар хэсэг чинь хэрэггүй юм байна шүү дээ. Энэний зүгээр хасчих л даа. Хоёрдугаарт, Засгийн газар үнэт цаас гаргах юм бол буцаад нөгөө 17.5 хувийн татваргүй гаргаж байсан тэр схем рүү орох гээд байгаа юм уу? Яагаад вэ гэх юм бол өнөөдөр инфляц чинь 16 хувьтай түүнээс доошоогоо ямар ч тэнэг хүн Засгийн газрын үнэт цаас худалдаж авахгүй шүү дээ. Тэгээд ямар эх үүсвэрээр санхүүжүүлэх гээд байгаа юм, ямар хэмжээтэй юм бэ? Нийт хэмжээ нь гээд асуугаад байна. Нийтийн хэмжээ нь ямар.

Ж.Ганбаатар: Сангийн сайд. Монголбанк дараа нь бас бэлдэж байгаарай.

Б.Жавхлан: Доржханд гишүүн ээ, битгий мушгиарай. Экспорттой холбоотой гэдгийг бид бүгдээрээ хүлээн зөвшөөрч ингэж ярьж байгаа юм. Дайн гэж ерөөсөө танд юу ч юм яриагүй. Энэ экспортыг ярих юм бол олон жилийнхээ горыг бид нар өнөөдөр амсаж байгаа байхгүй юу. Бид нарт маш хүнд тусаж байна, маш хүнд тусаж байна. Энэ төмөр замын тээвэр ложистикийн асуудлаас болоод бие биеийгээ улс төржиж унагааж байсан бодлогууд дээр унагаасан. Энэ байдлаас болоод бид маш олон жил маш олон боломжийн экспортуудыг алдсан. Жишээ нь Гашуунсухайт дээр экспорт хийж байсан. Хийхдээ хийснийхээ талыг нь бид нар гадна талдаа далд эдийн засаг дээрээ алдчихсан. Жилдээ бид нарын тооцоогоор бол 1.4-1.7 тэрбум доллар бид нар далд

эдийн засагтаа алдсан. Өөрөөр хэлбэл, тэр хэмжээгээр бид нар валютын нөөцөө зузаатгах боломжуудаа алдсан байхгүй юу. Дотоодын үйлдвэрлэлүүдээ бид нар хангалттай эдийн засаг авч явах иймэрхүү хямралыг эсэргүүцэх чадвартай хэмжээнд байгуулж ирж чадаагүй, тогтолцоогоо болгож чадаагүй. Энд урт хугацаанд.

Ж.Ганбаатар: Монголбанк гишүүний асуултад хариулъя, 5 номер.

Б.Лхагвасүрэн: Доржханд гишүүний асуултад хариулъя. Мэдээж одоо шууд зах дээр байгаа бэлэн мөнгийг эргэлтэд оруулаад ингээд явах нь бол тэртээ тэргүй одоо байгаа хууль эрх зүйн зохицуулалтаар бол чөлөөтэй байгаа юм. Гэхдээ ажлын хэсэг дээр яаж ярьсан бэ гэхээр, ингэх байх аа, тэгэх байх аа гэж таагаад юмаа хийгээд явах юм бол мэдээж тодорхой хэмжээний бас асуудал үүсвэл дахиад л энэ асуудал яригдах болох учраас нэг мөсөн ажиллаж байгаа механизм дээрээ нэмэлт маягаар ийм санхүүжилт хийнэ, жишээлбэл тухайн банк нь өөрөө өөрийн зохистой харьцаагаа алдах гээд байвал энэ дээр нь Төв банк яах юм, тодорхой хэмжээний жоохон мөнгө дутаах юм бол Төв банкны зүгээс репо санхүүжилт дээр яаж оролцох юм гэдгээрээ л саяын тэр хуулийн заалтууд чинь хоорондоо нийцсэн маягаар орж ирсэн байгаа л гэж харж байгаа.

Ж.Ганбаатар: Доржханд гишүүн хариулт хангалтгүй гэж үзвэл 1 минутад сунгаж асууж болно. Доржханд гишүүн.

Т.Доржханд: Тэгэхээр бид нар эдийн засгийн онол гэж байдаг. Монголбанкныхан, Сангийн яамныхан мэдэж байгаа шүү дээ. Жавхлан сайд бол мэдэж байх ёстой. Одоо тэгээд онол хэрэггүй ээ гээд. Олон улс даяар чинь уламжлалт бус мөнгөний бодлого чинь явцгүй байсан гээд ОУВС, олон улсын төв банкууд бүгдээрээ хүлээн зөвшөөрчихсөн шүү дээ. Гэтэл одоо ингээд тексбүүк биш ээ, онол биш ээ гэсэн байдлаар явж болохгүй ээ.

Та нар мөнгө зах зээл рүү нийлүүлэх гээд байна шүү дээ, энүүгээр чинь, хямд эх үүсвэр. Тэгээд төсөв ч өөрөө тэлчихсэн, мөнгөний бодлого нь ч гэсэн тэлчихсэн ийм тохиолдолд чинь дахиад л ханшин дээрээ дарамт цохилт өгнө шүү дээ. Ойлгомжтой шүү дээ. Ийм байхад чинь одоо ингээд мөнгө нийлүүлнэ, тодорхой хэсэгт гээд. Тэгээд хоёрдугаарт яг хэдий хэмжээний эх үүсвэр юм бэ гэдэг дээр тодорхой хариулчих л даа. Түрүүн Үнэ тогтворжуулах хөтөлбөр чинь 6 их наяд байсан. Одоо хэдэн их наяд юм бэ? Та нар хэд гэж төсөөлж байгаа юм бэ? Тэгээд мөнгөө гаргахдаа төсвөөс ч юм шиг, үгүй ч юм шиг ийм байдлаар ингээд тойруулаад байх юм. Мэдээж тэр төсөв дээр чинь мөнгө байхгүй шүү дээ. Тэгээд үнэт цаасаа гаргах гэж байгаа бол хэдэн хувиар гарах гэж байгаа юм.

Ж.Ганбаатар: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Одоо энд онол ярьж бие биедээ цэцэрхэх гээд яах вэ? Маш тодорхой зүйл гэх юм бол Төв банк саяхан бодлогын хүүгээ бүр 2.5 хувиар нэмчихсэн. Өөрөөр хэлбэл нэг төгрөгийн ч нэмэлт мөнгөний нийлүүлэлт хийхгүй гэдгээ албан ёсоор бодлогын шийдвэр гаргаад зарлачихсан. Ямар ч эдийн засгийн оюутан одоо ийм цагт мөнгөний нийлэлтийг нэг төгрөгөөр нэмэх юм бол эргээд Төв банкны валютын нөөц дээр ямар дарамт болж ирэх вэ гэдгийг хэн ч хэлж мэднэ. Тийм учраас энэ хуулиар зохицуулагдах хүрээнд мөнгөний бодлого, төсвийн бодлогын хүрээнд одоо мөнгөний нийлүүлэлтийг нэмэх ямар ч орон зай байхгүй. Одоо нэгэнт түлхээд гаргачихсан байгаа, эргэлтэд байгаа банкнуудын эх үүсвэр дээр байгаа Төв банкан дээр ирээд байгаа энэ эх үүсвэрүүдийг түрүүн Хүрэлбаатар дарга хэлсэн, хөшиж гаргах хүүгийн татаас ч юм уу, мөн авчирч нийлүүлэх татан авалтыг нь урамшуулах, гаалийн албан татвар.

Ж.Ганбаатар: Д.Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Д.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгэхээр ямарваа нэгэн юманд бас нэг үйлийн үр гэж байдаг юм байна. Яг арван жилийн өмнө Үнэ тогтворжуулах хөтөлбөр гэж яригдаад энэ асуудлыг бид нар бас шийдээд алдаа, оноотойгоор л бас энэ цаг хугацааг тууллаа л даа. Одоо энд ингээд яриаг бид нар ингээд нийтээрээ өөрсдийнхөө ярьсан бөгөөд бусдынхаа ярсан үгийг сонсоод байхад тэр 2012-2016 оны алдаа нь өнөөдөр энд тусаад байна гэдэг болохоос биш 2016-22, зургаан жил энэ зай орон зайг байхгүй юм шиг ярьдаг. Ямарваа нэгэн алдааг нэг, хоёр жилийн алдааг бүхэл бүтэн зургаан жилийн хугацаанд бол засаглаж байхдаа засах асар их боломж байдаг. 2024 онд 2012-2016 оныг ярьж байх юм уу, 2016-гаас энэ 2024 оныг ярьж явах юм уу, мэдэхгүй байна. Тэгэхээр улс төрийн хүчин нь ямарваа нэгэн улс төрийн хонжоо олох гэж заавал эсрэг хүчнийхээ алдаа оноог нь ярьдаг болохоос биш өөрсдийнхөө алдаа оноог хардаггүй. Энийгээ, яасан юм, тэр нь өөрөө яаж энэ хүндрэлээс гарах вэ гэдэг юмыг нь хаагаад тэр цаг нь барагдчихаад байна.

Тийм учраас бид нар энэ яалт ч үгүй өнөөдөр төр, засаг байгаа юм чинь энэ үнийн тогтворжилтын асуудлыг бол шийдэх ёстой. Энэ асуудал жоохон хоцорч явж байгаа гэдэгтэй бол санал нэг байгаа. Эдийн засгийн байнгын хороон дээр бид нар бас дээр ярьж байсан. Эдийн засгийн байнгын хороон дээр яригдах, хэлэлцдэг асуудал бол эдийн засгийн асуудал. Дандаа хөгжлийн асуудал. Энэ нөгөө хүндрэлтэй байгаа асуудлыг яаж давах вэ гэдэг асуудал байгаа юм. Энэ нь өөрөө зөвхөн өнөөдөр ойлгомжтой шүү дээ, экспортын асуудал. Бүгдээрээ мэдэж байгаа, одоо машины тоо ярьдаг болсон, нүүрсний экспортын асуудал. Тийм учраас энэ хүндрэлүүдийг бид нар шийдэх гэж нэлээн мөнгө төгрөгийн асуудал хэвлэх үү, төсвөөсөө мөнгө хүүд нь нэмж өгөх үү, яах вэ гэдэг асуудлууд гарна. Тэгэхээр энэ цоорхойгоо цаашдаа яаж нөхөх юм бэ? Тэгэхээр нүүрснийхээ экспортыг нэмэгдүүлэх энэ чиглэл, энэ бүтээн байгуулалт руугаа мөнгө шахаач ээ. Энэ тогтоолынхоо төсөл дээр экспортыг нэмэгдүүлэх чиглэл рүүгээ жоохон тодорхой гол юмандаа анхаарал хандуулбал яасан юм бэ л гэж хэлэх гээд байгаа юм.

Энэ дээр 1 жижиг сажиг юм байна л даа. Дэлхий дээр нийтдээ олон орон та нар мэдэх байх. Нэг хүн 10 мянган долларын л эрхтэй байдаг шүү дээ. Тэгээд Монгол Улс чинь одоо ядуу учраас 6200 доллар, 20 сая төгрөг гэж яахаараа ингэж ард түмнээ ялгаж байдаг юм бэ? Энэ чинь цөмөөрөө л бусадтай адилхан байг л дээ. Хаана ч өнөөдөр 10 мянган доллар гэж байдаг шүү дээ. Энэ дээр тиймэрхүү мэтийн жижиг сажиг юм орж ирээд байна. Тэгэхээр экспортыг дэмжих энэ чиглэлдээ л жоохон мөнгө шахах талын юмыг нь өөрөө энэ үнэ тогтворжуулах чиглэл дээр гол зүйл байх ёстой.

Бид нар өнөөдөр ингээд өнөөдрийг аргалаад өнгөрч болно. Яаж мөнгөө нөхөх юм, яаж эдийн засгийн агшилтаа барих юм? Инфляц нь 17 хувьтай байхад бид нар ямарваа нэгэн дахиж мөнгө төгрөг босгох гэдэг асуудал хүндэрчихлээ шүү дээ. Тэгэхээр энэ асуудал дээр экспортоо илүү анхаараач л гээд байгаа юм. Энэ дээр энэ тогтоолынхоо төсөл дээр энэ чиглэлийн ямар юм байна? Тэгээд хоёрхон өргөн, нарийн цариг гээд хооронд 15 километрийг л хурдан барь л даа. Тэгтэл 20 сая тонн нүүрс гараад эхэлчих юм бол КОВИД-оос хамааралгүйгээр, жолоочоос хамааралгүйгээр нөгөө төмөр зам нь яваад эхэлчихнэ. Өөр өчнөөн арга байна шүү дээ, конвьерын асуудал гэж байна. Тэгэхээр энэ асуудлууд дээр жоохон анхаарахгүй бол бид нар яг өнөөдрийг нэг аргалсан тийм маягийн юмнууд л явагдаад байна л гэж би хараад байгаа юм. Энэ дээр хэдүүлээ ямар нэгэн байдлаар нэг нийгээ шүүмжлэх биш, зүгээр хамтдаа Монгол Улсын өнөөдрийн хүнд байдлыг хамтдаа авч гарах ёстой л гэж бодож байгаа юм. Энэ тогтоолын төсөл дээр энэ асуудал тусахгүй бол, энэ дээр нэлээн анхаарал хандуулаач ээ.

Ж.Ганбаатар: Жавхлан сайд гишүүний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Бат-Эрдэнэ гишүүн ээ, арван жил гацаасан наад хилийн солбицлын асуудлуудыг чинь сая бид нар шийдчихсэн шүү дээ. Ганцхан өдөр шийдсэн. Ганцхан өдөр шидчихсэн байхгүй юу, бид нар сая Олимпын үеэр очиж зочлохдоо, арван хэдэн жил гацаасан юмнуудыг чинь. Гэхдээ яах вэ ингээд хилийн асуудлаа шийдсэн ч гэсэн энэ өргөс авсан юм шиг хил дээр байгуулах тэр боомтын терминалын бүтээн байгуулалтууд чинь нэг жил, хоёр жил бас шаардах юм байна. Энэ ажлуудыг бид хийж байгаа. Ялангуяа бондын сэргээлтийн хүрээнд, та ч өөрөө их дэмжиж ингэж ажиллаж байгаа, баярлаж байна. Бид хэдүүлээ цуг явсан, боомтууд дээр. Тэгэхээр энийг бидний хувьд бол асуудлуудыг маш том түгжээнүүдийг тайлсан, маш том урагшаа алхсан ийм ажлыг богино хугацаанд амжуулсан шүү. Манай Засгийн газрын хувьд. Энэ дөрвөн жил ард түмэн энийг шийд гэж. Ийм түгжээнүүдийг тайлаа гэж бидэнд сонголт хийж эрх өгсөн, үүрэг өгсөн. Энэнийхээ хүрээнд одоо амжилттай ажиллаж байгаа гэж ингэж харж байгаа. Бүтээн байгуулалтын ажлууд дээр хамтарч сайн ажиллаж биднийг энэ бодлогуудыг дэмжээрэй.

Энэ хууль бол харин богино хугацааны асуудал. Богино хугацааны энэ нийлүүлэлтийн шок, богино хугацаанд гарч байгаа. Энэ хүндрэлүүдийг аль болох эдийн засгийн гэмтэл багатайгаар, дунд, урт хугацаанд хийгдэх саяын таны хэлж байгаа энэ бүтээн байгуулалтын ажлууд дээр хүнд тусахгүйгээр бид давж гарах ийм л хуулийн зохицуулалтыг оруулж ирж байгаа юм. Баярлалаа.

Ж.Ганбаатар: Д.Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя, 1 минут.

Д.Бат-Эрдэнэ: Тэгэхээр энэ хоёр төмөр замын асуудлыг ярихаар бид нар ийм тийм юм яриад байх юм бол одоо монголчууд бид нар ийм хов жив хэрүүлд сурчихлаа шүү дээ. Одоо бүтээн байгуулалтаа ярья. Эдийн засгаа сэргээх, энэ агшилтыг нь барих ганц арга бол одоохондоо бид нарт нүүрсний экспорт. Нүүрсний экспортыг КОВИД-оос хамааралгүйгээр бид нар гаргах, нэмэх боломж нь өөрөө тэр хоёр замыг холбох асуудал байгаа байхгүй юу. Хоёр зам дээрээ маш хурдтай холболт хийгээч ээ, маш хүчтэй ажиллаач ээ. Тэр рүү мөнгө шахаач ээ. Засгийн газрын гишүүд нь ээлж ээлжээр очиж тэнд зогсооч ээ. Тэрийг л хүсээд байгаа юм.

Ж.Ганбаатар: Санал хэллээ. Баттөмөр гишүүн асуулт асууя.

Б.Баттөмөр: Миний асуух гэсэн асуултыг одоо гишүүд асуучихлаа. Асуулт, хариулт бас нэлээн тодорхой явж байна. Энэ байдал бол цаашдаа улам хүндэрнэ. Тэгэхээр энэ хүндэрсэн үед, энэ хүндрэлийг сөрөх тийм потенциал бол манай Монголын эдийн засагт бол алга байна. Тийм учраас цаашид яах вэ гэдэг дээрээ бас их тодорхой зүйлүүдийг бодож, тооцож ингэж ажиллах шаардлагатай. Энэ хуулийн төслийг бол дэмжээд цаашаа явуулах нь зүйтэй гэсэн саналтай байна. Энэ тав, гэчхээд долоо гээд явчихсан байх юм. Энэ зургааг хаячихсан юм уу, эсвэл би буруу хараад байна уу? Энийг нэг хэлж өгөөч гэсэн. Энэ асуулт байна.

Хоёрдугаарт нь, ямар асуултууд байна гэхээр зэрэг Монголын ард түмэн энэ 30 жил хямралтай явж ирсэн. Өнөөдөр 3000 орчим төгрөг болчихсон байна шүү дээ, 1 доллар. Ардчилал зах зээлийн нийгэмд шилжиж байх үед хэд байсан, өнөөдөр 3000 гэдэг чинь 30 жилд байнга монгол төгрөг үнэгүйдэж ирсэн. Дээрээс нь их өрийг тэглээд өргүй байсан. Тэгээд өнөөдөр 33.2 тэрбум долларын өртэй болчихсон байгаа юм. Тэгэхээр монголчууд бид нар 30 жил хямралтай нүүр тулж явж байна л даа. Өнөөдөр юу вэ гэхээр илт гарч ирж байгаа учраас одоо бид энэ дээр ийм арга хэмжээ авъя гэж оруулж ирж байгаа юм байна л даа. Хямрал бол байнга өдөр тутам явж ирсэн гэдгийг би хэлээд байгаа юм. Тэгэхээр Эйнштэйний нэг хэлсэн үг байдаг л

даа. Болохгүй байгаа зүйлийг болж байгаа юм шиг явуулаад, тэрнээсээ үр дүнг хүлээгээд байдаг хамгийн том тэнэг л юм гэж. Би цэцэрхэж цэнэглэж хэлж байгаа юм биш. Энэ Эйнштэйний хэлсэн үг юм байгаа юм.

Бид нар энэ 30 жилийн хугацаанд болохгүй байгаад байгаа юмыг л болох гэж байгаа юм шиг л үр дүн хүлээгээд байхад бол хамгийн буруу зүйл маань энд л байгаад байгаа юм л даа. Би энд өнөөдөр хямарчихсан үед бол их цэцэрхэж байгаа юм биш. Би энд хөгжлийн загварын асуудлыг ярих гэж байгаа юм. Би энийг Их Хурлын гишүүн болсон зургаан жилийн хугацаанд ярьж байгаа. Болохгүй байна аа, энэ чинь. Энэ болохгүй байгаа юмыг болох талаас нь бодъё л доо. Яг ингээд яваад байх юм уу? Тэр Адам Смитийн Үл үзэгдэгч гар гэдэг чинь бол моодноос гарчихсан. Аль 2008 оны хямралын үед л моодноос гарчихсан шүү дээ. Тэгэхээр одоо Монгол Улсын онцлогт тохирсон энэ хөгжлийн загвараа л бид гаргаж ирж ажиллах ийм шаардлага үүсээд байгаа юм л даа. Тэгээд энэ дээр одоо ярьдаг юмнууд алга, ерөөсөө.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд бол монголчууд нефтийн үйлдвэртэй болчих боломж байсан уу гэвэл байсан л байхгүй юу. Дарханд үйлдвэр байгуулна гээд маш сайн төсөл Япончууд санал болгосон. Юу ч болгоогүй хаясан. Өнөөдөр Дорноговьд одоо байгуулах гэж байгаа юм. Түүхий нефтийн хараанаас авах гэхээр бас байхгүй. Тэр 500-гаад километр газраас хоолой татаж авна гэж байгаа юм. Хоолой татаж авлаа гэхэд 23-хан хувь нь Монголд ноогдож байгаа шүү дээ. Ийм л болчхоод байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар бол энэ хөгжлөө яаж төлөвлөх юм, цаашдаа энийг л их сайн тооцож үзмээр байгаа юм.

Сая Сангийн сайдын сүүлийн үед энэ далд эдийн засгийн талаар нэлээн их сайн ярьж байгаа. Би бол санал нэг байгаа. Монгол Монгол Улсыг хөгжүүлэх олон гарцуудын нэг нь бол энэ далд эдийн засагтай тэмцэх. Энэ дээр тээвэр ложистик дээр байна, алтны уурхайнууд дээр байгаа шүү дээ. Хувь хүн хувиараа олборлодог тийм лицензбол байхгүй. Дандаа аж ахуйн нэгжүүд байгаа. Тушааж байгаа хүний 70, 80 хувь нь хувь хүн тушааж байгаа шүү дээ.

Ж.Ганбаатар: Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 5 номер гишүүний асуултад хариулъя.

Б.Лхагвасүрэн: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Сая, би цаасан дээр зургаан номер байхгүй байна гэдэг нь техникийн л алдаа байх.

Ж.Ганбаатар: Адьшаа гишүүн асуулт асууя.

Ш.Адьшаа: Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдаас. Энэ улс оронд үүссэн нөхцөл байдалтай цаашид үүсэх нөхцөл байдалтай холбогдуулж энэ хуулийн төслийг оруулж ирсэн гэж ойлгож байгаа. Валютын нөөц гээд энэ асуудал чинь яг 3.4 тэрбум доллар нь яг байгаа юм уу? Энийг албан ёсоор хэлээрэй, Монголбанк, сангийн сайд. Дээр нь энэ ажлын байр 10их наяд, КОВИД-ын хөтөлбөр гээд бид энэ хугацаанд олон эдийн засагтай холбоотой маш их хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулсан ийм хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн хоёр жилийн хугацаанд. Гэтэл энэ чинь өнөөдөр ямар ч эдийн засгийн үр дүн өгөөгүй ийм нөхцөл байдал харагдаж байгаа шүү дээ. Өгсөн л гээд байгаа. Өгсөн юм ерөөсөө байхгүй байгаа. Энийг бүр хариуцлагатай хэлье.

Дээр нь экспортыг дэмжих ямар бодлого өнөөдөр энэ хуулийн төсөлд оруулж ирсэн бэ? Экспортыг хязгаарлах л энэ бодлогыг өнөөдөр энэ хуулиар оруулж ирлээ. Зөв байх. Яагаад гэвэл үндэсний аюулгүй байдлын ард иргэдийнхээ хүнсний хангамжийг сайжруулах талаар ийм бодлого явуулж байна гэж ойлгож байгаа. Гэхдээ энд Сангийн сайдаас нэг зүйлийг асууя. Энэ хуулийн 5.1.5-д шаардлагатай

тохиолдолд банкнаас зээл олгоход тавигдах зохистой харьцааны болон бусад шалгуур үзүүлэлт, зээлийн шаардлага, нөхцөлийг тусгайлан тогтооно гэж. Энэнийг чинь тодорхой тайлбар авмаар байна. Өнөөдөр Хөгжлийн банк, бусад Үнэ тогтворжуулах хөтөлбөр гэзд өнөөдрийн банкны зээл олгох, хууль тогтоомжоос гадуур үйл ажиллагаа явуулдаг ийм нөхцөл байдлууд дээр одоо тодорхой болсон байгаа шүү дээ. Ийм нөхцөл байдлыг бий болгохгүй юм байгаа биз дээ? Энэ зээл олгох шалгуураас тусгай зориулалтаар зээл олгоно гэж байгаа дээр чинь тайлбар авмаар байна. Энэ ямар учиртай ийм хуулийн төсөл оруулж ирж байгаа юм бэ?

Бид өнөөдөр энэ зээл олгох зээлтэй холбоотой, Хөгжлийн банктай холбоотой Үнэ тогтворжуулах хөтөлбөрүүдтэй холбоотой, ЖДҮ-тэй холбоотой олон асуудалд ороцолдож, өнөөдөр энэ цаг үеүдэд бид ямар байдалд орчхоод байгаа вэ? Энэ талаар нэг тайлбар авъя.

Ж.Ганбаатар: Жавхлан сайд гишүүний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Адьшаа гишүүнд асуултад нь хариулъя. КОВИД-ын хууль түүхэн үүргээ гүйцэтгэж байгаа, гүйцэтгэсээр байгаа. Өнгөрсөн 2020, 2021 оны хугацаанд бид хүндээ ч гэсэн, эдийн засгаа ч тэр, эрүүл мэндээ ч аварч гарч чадсан, чадсан шүү. Олон жилийн түүхийн босгон дээр, олон жилийн түүхийн тавцан дээр энийг үнэлэх тийм цаг хугацаа бидэнд ирээдүй байгаа гэж ингэж харж байгаа юм. Би танд хэдхэн тоо хэлье. 2019 онд эдийн засаг 5 хувийн өсөлттэй байсан. 2020, 2021 онд, жишээ нь 2020 онд бид хасах 5 хувь хүртэл эдийн засгийн уналт хийсэн. Шууд КОВИД-ын нөлөөгөөр. Засгийн газар бүх л арга хэмжээг авсан. Эрүүл мэндээ ч хамгаалсан, эдийн засгаа сэргээхийг хичээсэн, ажилгүйдлийг хамгаалсан. КОВИД-той холбоотой амь нас, эрсдэлийг хамгаалж чадсан. КОВИД-ын тохиолдолтойгоо харьцуулах юм бол манайх КОВИД-оос болж амь эрсэдсэн ийм рейтингээрээ цөөхөн таван орны нэг үлгэр жишээ болж чадсан. Энийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хэлж үнэлж байгаа, би хэлээгүй. Энэ талаар олон тоо хэлж болно. Та завгүй байгаа байх аа, сүүлийн үед сонгууль энэ тэр гэзд маш завгүй, энийг үзэх харах, аргагүй аргагүй.

Экспортыг хаах, боомилох хууль заалт энд байхгүй ээ. Экспорт импорт, гадаад худалдааны асуудал бол мэдээж дунд, урт хугацааны асуудал. Богино хугацааны энэ нийлүүлэлтийн шок үүсэх, богино хугацааны энэ үнийн хөөрөгдлийг бид аль болох зөөллөж оруулж ирэх ийм арга хэмжээнүүдийг авъя гэзд, хуулиар байдаггүй Засгийн газарт эрх байдаг, хуулиар байдаггүй Монголбанкны боломжуудыг нь энүүгээр бас тавьж өгч байгаа юм. Тэгэхдээ Их Хурал дээр энийг шийдэж өгөөч гэж байгаа юм. Хууль тогтоох дээд байгууллага, та өөрөө оролцоод энийг нэг зааж өгөөч гэж байгаа юм.

5.1.5, энийг та сайн уншаарай. Бүх төрлийн зээл, бүх төрлийн энэ банкны үйлчилгээн дээрээ хийж байгаа зүйл огтоос биш. Шатахуун, мах, гурил ийм гурван бүтээгдэхүүн. Тэрэн дундаа зөвхөн шатахуун дээр шүү. Үнийн өсөлтөөс болоод арван төгрөгөөр арван литр авч чаддаггүй байсан бол одоо арван төгрөгөөрөө, магадгүй найман литр долоон литр авдаг болж ирж байгаа импортлогч нар. Өөрөөр хэлбэл, нөөцөө татаж чадахгүй хэмжээнд ирж байгаа байхгүй юу. Банкны хуулийн хязгаарлалт 20 хувь гэдэг хязгаарлалтаасаа болоод. Тийм учраас стратегийн бүтээгдэхүүний хувьд хангалттай нөөц татах хэмжээнд нь зориулж Засгийн газар тэр зөрүүн дээр нь баталгаа гаргаж өгье гэж байгаа юм. Мэдээж эргэн төлөгдөхдөө эхлээд Засгийн газрын баталгаагаа суллана, эрсдэлгүй байх ёстой.

Ханш дээр нь, жишээ нь тогтвортой ханшаар валютын эх үүсвэрийг нийлүүлнэ. Тэрийг нь шилжүүлэх тэр эрсдэлээс нь Төв банк хариуцаж ингэж зохицуулалт хийнэ гэсэн гэх мэтчилэн ийм заалт байгаа юм. Тэрнээс биш хавтгайруулан жижиг, дунд

үйлдвэр, Хөгжлийн банк, арилжааны банкны арилжааны зориулалттай зээлүүдийн зохицуулалт огт энд хамааралгүй. Тэр чинь бол тусдаа хуулиараа тусдаа хяналтаараа ингээд явна.

Ж.Ганбаатар: Адьшаа гишүүн тодруулъя, 1 минут.

Ш.Адьшаа: Жавхлан сайд уучлаарай, та их бухимдалтай байгаа юм байна. Аргагүй л дээ. Тэр сонгууль энд ямар ч хамаагүй шүү. Энэ үнэхээр тийм КОВИД-ын хууль, 10 их наядын хөтөлбөр чинь өнөөдөр үр дүнгээ өгсөн юм бол энэ ажилгүйдэл, үнийн хөөрөгдөл яагаад газар авчихсан, өнөөдөр Монгол Улсын эдийн засаг яахаараа элгээрээ хэвтчихсэн байдаг юм бэ? Ийм хариуцлага юм та ярихаа болимоор байна.

Хоёрдугаарт нь, би ойлгохгүй байгаа юм уу, 5.1.5 гэдэг, энэ чинь шаардлагатай тохиолдолд банкнаас зээл олгоход тавигдах зохистой харьцааны болон бусад шалгуур үзүүлэлт, зээлийн шаардлага, нөхцөлийг тусгайлан тогтооно гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь зээл олгох асуудлыг л тусгаарлан тогтооно гэдэг энэ асуудал чинь урьд Хөгжлийн банк энэ тэр гарч л байсан шүү дээ. Тэгээд яагаад энийг асуухаар ингэж.

Ж.Ганбаатар: Монголбанкны ерөнхийлөгч гар өргөөд байна. Эхлээд хариулчих. Дараа нь Сангийн сайд хариулъя. 5 номер.

Б.Лхагвасүрэн: Адьшаа гишүүний асуултад хариулъя. Эхний асуулт нь нөөцтэй холбоотой асуулт байсан. 3 сарын 31-нээр Монгол Улсын валютын нөөц 3.3 тэрбум доллар. Албан ёсны статистик тоо байгаа л даа. Хоёр дахь, саяын тодруулж байгаа асуулт дээр бол нефть импортолдог компаниудын хувьд одоо төвөгтэй зүйл нь барьцаа хөрөнгө дээрээ байдаг юм байна лээ. Ялангуяа шатахуун буюу эргэлтийн хөрөнгө. Эргэлтийн хөрөнгө нь яг банкныхаа өөрийнхөө зохистой харьцаагаар бол барьцаа гэж тооцогдохгүй гээд яваад байгаа юм. Тэгэхээр бол одоо орж ирээд нэгэнт улсын гэдгээрээ нөөц бүрдүүлээд энэ хуулийн хүрээнд ингээд тодорхой хугацааны нөөц бүрдүүлээд явсан тэр шатахууныг барьцаа хөрөнгөд нь бас тооцуулах тухай асуудлыг энэ дээр бас хөндөж ярьж байгаа юм.

Ж.Ганбаатар: Жавхлан сайд 1 минут, хариулъя.

Б.Жавхлан: Адьшаа гишүүн ээ, та ганцхан хором зарцуулаад өмнөх хуудсыг нь эргүүлээд харчхаарай. 3.2 дээр ингэж байгаа. Энэ хуулийн 3.1-д дор дурдсан бараа бүтээгдэхүүн хамаарна. 1/газрын тосны бүтээгдэхүүн, 2/гурил, 3/ мах гээд. 5.1.5 дээр чинь энэ гурван бүтээгдэхүүн дээр нөөц бүрдүүлэхэд хэрвээ Банкны хуулийн шалгуур үзүүлэлтүүдэд хязгаарлалтад ороод нөөцөө татаж чадахааргүй бол энэ дээр нь тусгайлан зохицуулалт хийхийг Төв банканд зөвшөөрч байгаа л ийм зарцуулалт юм байгаа юм.

Ж.Ганбаатар: Би хоёр, гурван асуулт. Асуулт ч бараг асуучихлаа даа, үг хэлье. Ер нь энэ хуулийг бол дэмжээд хэлэлцэх эсэхийг нь бас Их Хурал дээр ороод ирэх байх. Ажлын хэсгийг Байнгын хороо байгуулах юм уу, Их Хурлын дарга байгуулах юм уу, одоо хэлж мэдэхгүй байна. Тэгээд тэр үед нь олон зүйлүүдийг нь засаад явах нь зөв байх. Нэг зүйлийг хэлэхэд бол эдийн засаг үнэхээр хүнд байгаа, гадаа. Бизнес эрхлэгч нар болоод ард иргэдийн нуруун дээр олон хүнд зүйлүүд бол байна. Энэнээс сэргийлэх, ийм байдалд хүрэхгүй байлгах гол хоёр хүн нь мөнгөний бодлогыг барьж байгаа, төсвийн бодлого барьж байгаа та хоёр шүү дээ. Тэгээд энийг одоо ийм байдалд хүргэсэн. Тэгээд асуудлыг их оройтуулж оруулж ирж байгаа юм. Тэгээд хэтэрхий, би бол байнга хэлдэг л дээ.

Төр ерөөсөө энэ мөнгөнд хэтэрхий замбараагүй ханддаг. Өөрөө олдоггүй учраас энийг хаанаас ч юм ундраад гараад ирдэг гэж боддог учраас энэ төрийн алба, ялангуяа энэ мөнгөтэй харьцаж байгаа хүмүүс хэтэрхий замбараагүй мөнгөтэй харьцдаг. Гаргаж байгаа шийдвэрүүд нь дандаа мөнгө бүтээх биш, үрэн таран хийх. Энэ чинь өөрөө бид нарыг ийм байдалд хүргэж байгаа юм. Хадгална арвижуулна гэдэг тийм бодлого ерөөсөө байхгүй. Асуудлыг дуусгана гэдэг хүн ерөөсөө алга байна шүү дээ. Бодлого ярина, маш том том том зүйлүүдийг ярина. Тэгээд ярьчхаад л орхичихдог дундаас нь. Дунд нь хүргэдэг юм уу, хүргэдэггүй юм уу мэдэхгүй. Эхлээд л орхиж байх шиг байна, зарим нь. Ийм замбараагүй төсөв мөнгөтэй, санхүүтэй харьцдаг ийм зүйлүүд чинь ерөөсөө сүүлийн 30, 40 жил ерөөсөө бид нарыг үнэхээр ангал руу унагаж байна л даа.

Би бол хажууд нь орж ирж суугаад одоо тав дахь жил, зургаа дахь жил рүүгээ орж байна. Үнэхээр мөнгөтэй яаж ингэж харьцдагийг нь гайхаж байгаа юм. Өөрсдөө олдоггүй, гараараа маажиж мэддэггүй, тийм асуудалд хуруу дүрж үзээгүй учраас ингэж харьцдаг юм уу? Нэг жоохон мөнгө болохлоороо ахиад төрөө данхар болгочихно, том том байгууллагууд нэмээд байгуулчихна. Тэгээд дотоодын нийт бүтээгдэхүүний бараг 60, 70 хувийг төсөв бүрдүүлж байгаа биз дээ? Тэгээд бүх зүйл төсвөөс хамааралтай. Одоо том сургууль төгсөөд ирсэн хүүхдүүд бизнесээ нээхгүй, дандаа л төрд орж ажиллах, эсхүл төртэй хамааралтай ажил хийх ийм сонирхолтой. Тэгээд хэн баялаг бүтээх вэ? Хэн энэ болж байгаа процессыг чинь тэтгэх вэ? Энэ бодлого ерөөсөө жилээс жилд үнэхээр хумигдаж байна. Үнэхээр ирээдүйдээ хэн ажил хийж, хэн энэ хөдөө аж ахуйд ажиллах вэ, хэн мал, тариаланд ажиллах вэ, хэн нь энэ барилга байшин барих вэ, одоо мэдэхгүй. Энэ бол үнэхээр, би одоо, энэ хуулиуд дээр нь гишүүдийн гаргаж байгаа санал дээр давхцуулаад асуулт асуугаад яах вэ?

Ер нь цаашдаа энэ мөнгөтэй харьцаж байгаа харьцаагаа ер нь засахгүй бол жоохон мөнгөний бараа харахаараа л хаа хамаагүй юм ярьдаг, хэтэрхий попордог. Ер нь энэ асуудал чинь л бүгдээрээ бид нар ийм байдалд хүргэж байгаа юм. Тэгэхээр энэ санхүү мөнгийг зөв зарцуулдаг, энд нь ямар тогтвортой байдлын юм гаргаж өгөх юм, тэр хууль руугаа ордоггүй, тэр хуулиа хүндэтгэдэг үе үеийн Засгийн газар энийгээ баримталдаг ийм бүр систем гаргаж өгөх л хэрэгтэй юм шиг байгаа юм. Бусад улсуудыг дуурайж байгаад ч хамаагүй. Тэгэхгүй бол нэг жоохон мөнгө олдог, энийгээ маш үрэн таран, маш ургүй зүйл рүү зарцуулдаг асуудал өнөөдөр энэ асуудалд хүргэж байгаа юм. Тэгээд энэ асуудал бол одоо дэмжихээс өөр арга байхгүй. Оруулж байгаа процесс маш их оройтсон. Бодлого оруулж байгаа дарга нар өөрсдөө их маш оройтсон. Тэгээд л бас Их Хурлын гишүүдийг хамаагүй загнаад байх хэрэг байхгүй болов уу гэж бодож байна.

Асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх байнгын хорооны гишүүд нэрсээ өгөхийг хүсье. Ихэнх нь асуучихсандаа, бараг. Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Хүрэлбаатар гишүүн үг хэлье.

Ч.Хүрэлбаатар: Би ч сая гишүүдийнхээ хэлсэн үгүүдийг нэлээд сайн сонслоо. Гэхдээ Бат-Эрдэнэ гишүүн үйлийн үр гээд ам асууж байна л даа. Үнэхээр тийм. Одоо яг энэ танхим дотор Ардын нам 2012-2016 онд байхад сөрөг хүчин байж байсан хүн ганцаараа л би байна. Тэр үед бид нар эрх баригчдын хэрэгжүүлсэн Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг үнэхээр шүүмжилсэн. Яагаад шүүмжилсэн юм бэ гэхээр бид нар яг хэрэгжүүлж эхэлж байх үеэс нь хараад ямар үр дүн гарсныг нь бүгдийг нь нүдээрээ үзсэн. Яг тэр эхлэлээс нь аваад дуустал нь, тэр дотор нь байгаа шүүмжлээд, үгээ хэлээд явсан учраас энэ Үнэ тогтворжуулах хөтөлбөр яг энэ өнөөдрийн өргөн мэдүүлж байгаа энэ хэлбэрээр үр дүнгүй гэдгийг нь би мэдэж байгаа юм.

Энэ бол төгрөгийн ханш уналтыг улам хөөрөгдөнө. Байгаа эдийн засагт байгаа мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлээд явуулчихаар энэ чинь очиж ханшийг хөөрөгдөнө. Валютын нөөц дуусна, хомстоно. Одоо хангалттай буучхаад байна шүү дээ. Тэгээд одоо хоёр ханштай. Нэг нь албан ёсны, нөгөөх нь ард түмэн, аж ахуйн нэгжүүдийн төлдөг. Нөгөө 2900 гэдэг бол тэр валютад эрх мэдэлтэй, ойрхон хүмүүст олддог ханш. 3200 гэвэл Найман шаргын ханш чинь ард иргэд энүүгээр авах гэвэл олохгүй байгаа ханш, олдохгүй байгаа ханш. Ийм нөхцөл байдлыг улам дэвэргэх зүйл энд ороод ирчихсэн учраас би энэ дээр бол шүүмжлэлтэй хандаж байгаа юм. Сөрөг хүчин байхдаа энэ үг зүгээр мэдэх биш, дотуур нь амьдраад ирсэн хүний хувьд хэлж байгаа юм.

Эдийн засгийн онолын талаар түрүүн Доржханд гишүүн хэлж байна. Энэ бүгд байгаа шүү. Тэр эдийн засгийн онол дээр яг энэ дээр бичигдсэн бүх зүйлүүд чинь амьдрал дээр болоод л явж байгаа. Тэгэхээр тэрийг бас үгүйсгэж болохгүй. Энд өрнөж байгаа зүйл бол эдийн засгийн зүйл тогтол, амьдралын дагуу л гарч ирж байгаа үр дүнгүүд. Үүнийх нь дагуу болохгүй зүйлүүдийг болохгүй байна, болдоггүй юм гэдгийг л хэлээд байгаа юм. Энийг сайн ойлгоцгоогоорой.

Яагаад би энэ Лхагвасүрэн ерөнхийлөгч өөрөөс чинь Үндэсний хөрөнгө оруулалтын банкийг асуугаад байгаа гэвэч. Та бол Үндэсний хөрөнгө оруулалтын банканд КОВИД-ын хууль ашиглаад мөнгө өгчихсөн байхгүй юу. Тэгэхээр би итгэхгүй байгаад байгаа байхгүй юу. Та нарыг сая Доржханд гишүүний хэлээд байгаа энэ заалт чинь хэрэггүй юм байна шүү дээ гэвэл байгаа заалт байна шүү дээ, зээл өгнө, мөнгө өгнө, дамжуулаад өгнө гэвэл байхад чинь итгэхгүй байгаа юм. Өгч болохгүй гэсэн хуультай байхад өгчихсөн, дарга нарынх учраас банканд. Тэгээд хойноос нь хөөцөлдөггүй нэхдэггүй. Ийм учраас би нэхээд байгаа юм. Ийм учраас энд гарч байгаа Үнэ тогтворжуулах хөтөлбөр гэвэл та нар мөнгө хэвлээд өгөх энэ мөнгөнүүд чинь бас яг энэ замаар явна. Тэгээд тэр мөнгө авсан хүмүүст нь мөнгө төлж байгаад хүнээ муулуулчихдаг, шүүмжлэлтэй хандаж болох сөрөг үг хэлчих хүнээ доромжилдог. Ийм зүйл болох учраас би Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн энэ хэлбэрээр дэмжихгүй.

Яагаад вэ гэхээр энэ ард иргэдийн улам л бодит орлогыг багасгах ийм үйл ажиллагаа. Та нар харж л бай. Үнийн хөөрөгдөлт улам нэмэгдэнэ. Ханш, валютын нөөц хомсдоно, төгрөгийн ханш унана. Ийм арга хэмжээ рүү түлхээд байна шүү дээ. Тэгэхээр энэ чинь эргээд Их Хурал хариуцлага хүлээнэ. Тийм учраас би энийг анхааруулаад одоо хэлж байгаа юм.

Ж.Ганбаатар: Доржханд гишүүн үг хэлье.

Т.Доржханд: Ер нь ямар улсад амьдраад байгаагаа ойлгохоо болилоо шүү. Хойд Солонгост амьдраад байгаа юм шиг мэдрэмж төрж байна. Өнөөдөр Монгол Улсын эдийн засагт оролцох төрийн оролцоо төсвөөрөө 40 хувь байгаа, нийт эдийн засгийн. Төрийн өмчийн компаниуд өнөөдөр өглөө бид нар АнЧам гэж байгууллага дээр танилцуулга хийсэн. Төрийн өмчийн хорооны даргынхаар бол 9.7 их наяд төгрөг төрийн өмчийн компаниудын зүгээс эдийн засагт оролцож байна гэж байна. Энэ дүнгээрээ нийтдээ 60 хувь нь бол төр байгаа. Төр хамгийн том татвар төлөгч, төр өөрөө өөрийгөө шагнадаг, төр иргэдээсээ ингээд холдчихсон. Одоо ингээд төр сайхан тогтворжуулна, үнийг чинь тогтворжуулна гэвэл. Нөгөө зах зээлийн эдийн засаг маань хаачихсан юм? Одоо онол хамаа байхгүй ээ, энэ чинь онол ярьдаг юм биш ээ гэвэл. Тэгвэл бид нар арван жил яах гэж эдийн засгийн онол судалж, номын санд суусан юм бэ? Онол байхгүй юм бол одоо тэгээд эдийн засагчдаар яах юм. Тэгвэл энэ Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч эд нар нь бүгдээрээ л Америкт сурч байсан шүү дээ. Яах гэж сурсан юм тэгвэл, тийм биз дээ? Тэгээд онолоо үгүйсгээд байдаг байж

болохгүй ээ. Эсвэл онолоо сайн судлах хэрэгтэй гэж хэлмээр байна. Яагаад вэ гэхээр тэр ОУВС, Дэлхийн банкны бүх эдийн засаг чинь текстбүүк дээр онол дээрээ явдаг юм, ирж байгаа бүх бодлогууд чинь явдаг юм. Та нар ирэхээр нь бүгдээрээ ингээд толгой дохиод суудаг шүү. Энд болохоор онол байхгүй гэж чанга ярьж болохгүй, сайхан мэтгэлцэж болно. Олны өмнө ямар онол байдаг юм, яагаад энэ болохгүй юм гэж мөн үү?

Одоо наад асуулт дотор байгаад байгаа үгээ хэлчихье. Газрын тос, мах, гурил дээр л асуудал байна. Энэ гурав дээр л ингээд шийдчихье гэж байна. Тэгээд газрын тос гэхээр чинь бид нар хойд хөршөөсөө авдаг. Сая Украин, Оросын энэ дайнтай холбоотойгоор монголчууд чинь дэлхийнхээ нөгөө талд нь гараад хойд хөршөө дэмжсэн шүү дээ. Тэгээд яагаад яриа хэлэлцээрээ хойд хөрштэйгөө ярьж чадахгүй байгаа нь жишээ нь. Би гайхаж байна. Тэгээд одоо энэ хүндрэлийг өөрсдөө шийднэ гээд явж байгаа бол энэ гадаад харилцаа чинь яг хаанаа байгаа юм бэ? Бид нэг цонхны бодлоготой байна гээд дуугарахгүй яваад байдаг. Гэтэл үр дүн нь эдийн засаг тал дээрээ хаана байгаа юм, яагаад ярилцахгүй байгаа юм?

Хоёрт нь, түрүүн мах нөөцөлсөн байгаа, хангалттай нөөц одоо гарахаа хүлээгээд байна гээд байна шүү дээ, тийм биз дээ? Гурил, би Болорчулуун гишүүнтэй санал нэг байна. Одоо ингээд импортынхоо татвараар оролдоод, яг ийм нөхцөлд бид нар хүнсний асуудал стратегийн хувьд чухал юм байна, дотоодынхоо үйлдвэрлэлийг дэмжих нь чухал юм байна гэж дөнгөж саяхан Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээрээ 28 арга хэмжээнээс бид нар нэгийг нь л хангачихна. Бусад нь хангахгүй байна гэдэг дотор чинь явж байгаа шүү дээ. Толгой дохиод сууж байсан шүү дээ. Тэгсэн мөртөө одоо ингээд импортын татвараа тэглэнэ ч гэх шиг. Ийм байдлаар явж байгаа бол бодлого хаана байна? Зөв юм уу, буруу юм уу? Би бол энийг буруу гэж бодож байгаа.

Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг бид нар өмнө нь хийсэн. Дэлхий даяараа зарим нь хийсэн. Манайх бол бүр зүгээр л фейл, уначихсан. Тодорхой хэсэг нь мөнгөө авдаг, авангуутаа доллар руу хөрвүүлээд хийдэг, мөнгө угаадаг. Эрх мэдэлтэй хэсэг нь 3 хувиар их хэмжээгээр мөнгө авдаг. Жирийн иргэд бол аваагүй шүү дээ. Хулгай болоод л дуусан шүү дээ энэ Хөгжлийн банк эд нартай адилхан. Тэгээд яагаад энэ загвараа өнөөдөр дахиж оруулж ирээд байгаа юм бэ? Тэгэхээр Монголбанк аа, хариуцлага тооцох асуудлыг тавина. Та нар маш богино хугацаанд 1 тэрбум доллар алдсан. Одоо ингээд юу ч болоогүй байхад долларын хязгаарлалт хийгээд, үр дүнд нь ингээд ханшийн хүлээлтийг бий болгочихсон. Ханш ингээд унаж байгаа. Иргэд чинь гадагшаагаа сургалтын төлбөрөө хийж чадахгүй байна.

Өнөөдөр хэрвээ би хүссэн мөнгөө хүссэн тэмдэгтээр авч чадахгүй бол банк дампуурдаг биз дээ? Та шууд ингээд хүчээр ингээд банкнуудаа дампууруулчихаж байгаа байхгүй юу. Эдийн засгаа бас ингээд чирээд унагачихаж байгаа юм. Энэ хариуцлагагүй үйлдэлд чинь бид нар хариуцлага тооцох ёстой юм. Ийм болохоор танд хариуцлага тооцох асуудлыг тавих болно. Гарц шийдэл нь юу юм бэ гэж. Тов тодорхой хэлэхэд ерөөсөө л экспортын орох урсгалыг л нээх ёстой. Энэ хаанаас вэ гэхээр урд хөрш байхгүй юу? Тэгэхээр Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа үнэн, Хүрэлбаатарын гишүүний хэлээд байгаа чинь үнэн шүү дээ. Өөрөө эрх барьж байгаа нам хүртэл.

Ж.Ганбаатар: Цэрэнпунцаг гишүүн үг хэлье.

Ц.Цэрэнпунцаг: Энэ хуулийг дэмжиж үг хэлж байгаа юм. Дэмжиж байгаа шалтгаанаа хэлчихье л дээ. Хамгийн гол нь тэр олон учир шалтгаан ярих юм бол гишүүд олон янзын бодолтой л байна. Хамгийн гол нь бид нараас хамаарахгүй, энэ

гадаад нөхцөл байдал ийм болчихлоо. Тэгээд энэнээс болоод шок орж ирвэл энэ бидэнд хамгийн хүнд тусна. Тэр дундаа Монголын ард түмэн, тэр дундаа орлого багатай, иргэдэд орлого багатай өрхүүдэд бол хамгийн их хүнд тусна шүү дээ. Энэ өрхүүдийн орлогын ихэнх хувь нь гурил, мах, тэгээд ганц нэг, ялангуяа Улаанбаатарт нэг унаатай. Ингээд л энэ гуравт чинь гол зардал чирэгдэл нь явчихдаг учраас бол бид нар хамгийн эмзэг энэ нэг хэсгээ хамгаалах нь бол төрийн үүрэг л дээ. Тэр үүргээ л хамгийн гол болгож, энэ Засгийн газар маань өөрчилж, ийм арга хэмжээ авъя, тэгээд нөхцөл байдал үүсвэл цаг алдахгүй арга хэмжээ авахад бэлэн ийм хуультай болж байгаа гэж үзэж ийм хууль оруулж ирж байгаа юм байна гэж дэмжиж байгаа юм.

Ер нь бол зүгээр цаашдаа бид нар экспорт, импорт гээд л яриад л явчихдаг. Тэгээд л импорт дээрээ татвар тавиад дотоодынхоо үйлдвэрлэлийг дэмжье гээд л ярьдаг. Хамгийн гол нь л бид нар экспортоо л нэмэгдүүлээд явах л ганц арга зам байгаа шүү дээ. Тэр бол өчнөөн жил яриад өнөөдөр бүтээгүй ийм байдалтай л. Олон жилийн бид нарын буруу явж ирсэн бодлого, яах вэ, бодлого гаргадаг, тэр бодлого нь хэрэгждэггүй. Тэнд нэг хувийн эрх ашиг, жижиг улс төр ийм юмнаасаа болоод л энэ том төслүүдээ зогсоодог. Ложистик, тэр зам тээвэр, хил гааль дээрээ орж гарах асуудал нь бол дандаа хувийн улс төрчдийн хувийн эрх ашиг, сонирхол үйлчлээд л өдий болтол ингээд явчихсан. Тэгээд энэ танхимд байж байгаа, ялангуяа сүүлийн 30 жил энэ улс төрд зууралдсан улсууд бол бүгд холбоотой. Бүгдийнх нь л, энд ямар нэгэн байдлаар энэ шийдвэр гаргаж оролцсон учраас бүгд одоо нэг нэгэн рүүгээ чихээд, буруу, зөвөө нэг нэгэн рүүгээ хатгаад байх юм энд байхгүй байх гэж бодож байгаа юм.

Хамгийн гол нь бид нар энэ экспорт руугаа чиглэсэн энэ бүтээгдэхүүн, өнгөрсөн алдаануудаа ингээд үргэлж давтаад яваад байвал хамгийн тэнэг шүү дээ. Тэгээд ч ер нь бид нарын ямар нэгэн дотоодын үйлдвэрлэл явуулъя, өөрсдийнхөө зах зээл дээр дотоодынхоо үйлдвэрлэлийг хамгаалаад импорт дээрээ татвар тавьж энэ тарифаа хамгаалалт хийе гэж яриад байдаг. Эцсийн эцэст манай дотоодын үйлдвэрлэл чинь өөрөө гол том орц нь бол импорт шүү дээ, тэр чигээрээ. Тэгээд дахиад л валют хэрэгтэй болно. Одоо алт дотоодоо үйлдвэрлэе гээд яриад байна. Бензин тос, нөгөө том үнэтэй техникүүд чинь бүгд бид нар үйлдвэрлэж чадахгүй шүү дээ. Тэгээд гол орц нь дахиад л валют шаардлагатай. Импортын том орцод.

Өнөөдөр будаа, тариа тарьж байна, үйлдвэрлэгчид гээд л бид нар орилоод байдаг. Нөгөө комбайн, бүх л техник, тэгээд нөгөө шатаадаг шатдаг тосолдог материал чинь бүгд валютаар авчирдаг. Тэгээд энийгээ гаргаж ирчхээд бид нар дотооддоо хийж байна гээд байдаг. Энэний цаана харагдахгүй тэр далд орц хэлбэрээр бол нөгөө л экспорт байхгүй бол бид нар гурил, будаа тарьж чадахгүй л байхгүй юу. Тэгэхээр нэг ийм зүгээр, дахиад цаашаа нэг, хоёр алхаад харахад л ерөөсөө л экспорт байхгүй бол бид нар ингээд л энд ийм байдалтайгаа л зогсож байна. Тэр экспортод цөөрснөө яаж цаашид нь экспортоо нэмэгдүүлэх вэ, экспортын орлогоо яаж бүрэн бүтэн барьж авах вэ гэсэн энэ бодлогоо л ярьж явах болохоос биш, өнөөдөр нэг ийм жижиг, жижиг юман дээр бол ингээд энэ хуулиа бас одоо унагачихмааргүй байгаа юм.

Хамгийн гол нь бид нар үйлчлэх ёстой, ард түмнээ хамгаалъя, ард түмнийхээ, ялангуяа энэ хүнд үед бол идэж уудаг, гол хэрэглэдэг бүтээгдэхүүнийг нь бол.

Ж.Ганбаатар: Болорчулуун гишүүн үг хэлье.

Х.Болорчулуун: Би одоо удаан үг хэлэхгүй ээ. Энэ Засгийн газрын сайд нар нь ч гараад явчихлаа, байхгүй байна. Монголбанкныханд одоо юу ч яриад байх вэ. Ер нь тэгээд Монголбанк ханшаа алдчихлаа, 3000 хүрчихлээ, 3000 хүрэхээс гадна давчихлаа. Хамгийн гол нь доллар олдохгүй боллоо. Яагаад ингэж байна гэхээр бид нар ганцхан тулгуурт эдийн засагтай экспортын уул уурхайгаар, ер нь уул уурхай гэдэг

чинь бол бас баталгаатай орлого гэж дэлхий нийтэд үздэггүй юм байна лээ шүү дээ. Уул уурхайн үнэ цэнэ графикаар явдаг. Нэг өсдөг буурдаг, нэг буурдаг. Заримдаа улс төрийн нөхцөл байдал ч юм уу, гадаад орны нөхцөл байдлаас болоод бүр хаагдчихдаг. Тэгээд ирвэл эдийн засаг нь хүндэрчихдэг. Тэгэхээр бол үндэсний үйлдвэрлэл, аж үйлдвэрлэл, дотоодын үйлдвэрлэлээ сайн хөгжүүлж байж улс орон өөрийн дархлаатай байна. Хүнээр бол биеийн дархлаа сайтай, тамир тэнхээтэй. Энэ дээр бол үнэхээр манай улсын бодлого алдагдсан. Бид аж үйлдвэрийн орон биш хэрэглээний орон болчихсон байхгүй юу. Наад захын эмээ л гаднаасаа авчихдаг. Тиймдээ ч доллар одоо ховордоод байгаа юм.

Энэ жил бол, одоо энэ хуулиар бол нефтиэс гадна мах, гурил, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдал, өсөлтийн тухай бодлогын хууль ярьж байна л даа. Хууль оруулж. Тэгэхээр хөдөө аж ахуй гэдэг бол ямар хэрэгтэй вэ. Бүх юмны үндэс болж ирдэг. Хэдийгээр хөдөө аж ахуйд татвар бага төлдөг ч гэсэн маш их ажлын байрыг бий болгож байдаг юм. Нийгэмд өөрөө маш том үүрэгтэй. Түүнээс гадна аж үйлдвэр хөгжих үндэс болж байдаг. Хөнгөн, хүнсний аж үйлдвэр чинь хөдөө аж ахуйгүй бол бодохын ч хэрэггүй байдаг байхгүй юу. Тиймдээ ч манайд аж үйлдвэр гэж байхгүй суларчхаад, ингээд доллар, валютынх нь үнэ өсчихөөд байна л даа.

Би дахиж хэлэхэд гурилын үйлдвэрт хөнгөлөлттэй зээлийн асуудал энэ тэр яригдаж байна. Тэрийг гурил үйлдвэрлэснээр биш, гаднаас импортоор будаа аваад машиндах гурил биш ээ. Зөвхөн дотоодын газар тариаланчдынхаа будааг аваад тээрэмдсэн гурилд нь л тэр хөнгөлөлт өгөхөөс биш, импортыг дэмжсэн бодлого байж болохгүй шүү. Энийг бол Монголбанк хэрвээ энэ хууль хэрэгжих журам гарвал ийм байдлыг тусгах хэрэгтэй гэдгийг бас хэлэх байна. Энэ жилийн хаврын тариалалт хэцүүднэ дээ. Ноднин будаагаа борлуулж чадахгүй олон аж ахуйн нэгжүүд дампуурлын ирмэг дээр очиход байна гэдгийг хэлье.

Ж.Ганбаатар: Бат-Эдэнэ гишүүн үг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Орж ирж байгаа хуулийн төслийг үндсэнд нь, үндсээр нь сууриар нь дэмжиж байгаа юм. Одоо эдийн засгийн ийм хүнд нөхцөл бий болчихлоо. Гадаад, дотоод нөхцөл байдал хүндэрчихлээ. Үнийн өсөлт асар өндөр болж байна, үнийн ялгаа их гарч байна. Ингээд цаашлаад явах юм тэгээд баян, хоосны ялгаа малгай гараад одоо бүр улс маань дампуурах тийшээгээ л хандах нь л дээ. Тэгэхээр энэ авч байгаа арга хэмжээ бол ямар ч байсан тодорхой хэмжээнд ард иргэдийнхээ нэн тэргүүний хүнсний хангамж болсон махтай холбоотой, гурилтай холбоотой. Тэгээд нефть, нефтийн бүтээгдэхүүн, импорттой холбоотой орж ирж байгаа нь бол бас болж байна. Энийг тэгэхдээ нэг засаж залруулах хэрэгтэй байх шиг байна. Энэ дээр гарч байгаа зүйл, заалтууд жаахан тодорхой байх хэрэгтэй байна. Нэн тэргүүнд ямар хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлэх юм, хэдий хэмжээний дэмжлэг үзүүлэх юм, банкаар дамжиж байгаа зээлүүд нь ямар хэмжээний татаастай байх юм, хэдэн хувьтай байх юм. Нөгөө нэг 3 хувийн хүүтэй зээл гээд бид нар гаргаж ирж байсан. Тэр чинь тодорхой л байсан шүү дээ. Цаана нь 6 орчим байсан байх аа, Монгол Улсын Засгийн газар тодорхой хэмжээний хүүгийн татаас зөрүүг нь бол өгч байсан. Тэрэн шигээ энийг жоохон тодорхой болгоод явах хэрэгтэй байна.

Хоёрдугаар асуудал үндсэндээ энэ үйлдвэрлэлтэй холбоотой, дотоодын үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх, хөгжүүлэх, дэмжих, тэгээд импортоо бас тодорхой хэмжээгээр орлох бүтээгдэхүүнээ нэмэгдүүлэх, экспортоо нэмэгдүүлэх гээд, бид нарын амны уншлага болсон нэг зүйл байгаа шүү дээ. Энийгээ бид нар ерөөсөө өнгөрсөн жилүүдэд хийсэнгүй. Зөндөө л ярилаа. Тэгээд мэдээж зах зээлийнхээ хуулиар явах нь зүйтэй л байх. Онолоор нь явах нь зүйтэй л байх. Гэхдээ төрийн

зохицуулалт гэдэг нэг зүйл байх ёстой шүү дээ. Одоо жишээ нь өндгөө бид нар дотоодоосоо хангах. Энэ КОВИД-ын үед чинь өндөг тасраад сүйд болсон шүү дээ. Жишээ нь өндгөө хангахын тулд эд нар яах юм, хэдий хэмжээний хэрэгцээтэй юм, хэдэн аж ахуй байгаа юм, хэдэн аж ахуй дээрээ нэмэх юм уу, эсвэл байгаа хүчин чадлаа нэмэх юм уу гээд л, тэгээд тэнд нь тодорхой хэмжээний дэмжлэг үзээд л болчихлоо.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дээр сүүгээ өөрсдөө хангаж чадахгүй л байна гэж байна. Тэгвэл сүү хангахын тулд хэдэн литр сүү хэрэгтэй юм, хэдэн аж ахуй ферм байх ёстой юм. Тэр аж ахуйн фермүүдээ тоог нь гаргаж байгаад, нутаг орноор нь бүсчилж байгаад гаргаж ирээд л, тэгээд л дэмжээд л гаргаад ирье л дээ. Ногоон байна уу, улаан байна уу, цэнхэр байна уу, ямар компани байх, хэн нь байх ямар хамаатай юм. Тэрийгээ шууд дэмжээд, дэмжээд явъя л даа. Олон жил ярьж байгаа шүү дээ, энэ чинь. Одоо яг энэ нөхцөл байдалтай тохиолдуулаад үйлдвэрлээд дэмжээд авах нэг ийм боломж бид нарт гараад ирлээ шүү дээ. Хүн болгон энийгээ харлаа шүү дээ. Аж ахуйн нэгжүүдээ дэмжихгүй бол болохгүй юм байна, үйлдвэрлэлийг дэмжихгүй бол болохгүй юм байна. Төр бид нар зэрэгцээд хийнэ гэж угаасаа байхгүй шүү дээ. Энийг чинь хэн хийх юм. Иргэд, аж ахуйн нэгж л хийнэ шүү дээ. Тэгэхээр тэр аж ахуйн нэгж, иргэдээ улаан, ногоон цэнхэрээр нь харахгүйгээр шууд тоо хэрэгцээг нь гаргаж ирж байгаад л тэдэндээ зориулсан тэр хөнгөлөлттэй зээл юу байх юм, ийм ийм бүтээгдэхүүнийг та нар гарга гээд.

Одоо хавар болж байгаа. Хөдөө аж ахуйн тариалалттай холбоотой асуудлууд байж байна. Үр тарианы тариалалттай холбоотой асуудал байж байж байна. Одоо энэ зун болтол хэрвээ боломж бололцоо бид нарт нөөц бололцоо байгаа юм бол, тэгвэл намар хүртэл ямар нөөц бололцоогоо бид нар ашиглах боломж бололцоо байгаад байгаа юм. Тариалалтад хэдий хэмжээний тонн будаа, юу хэд хэрэгцээтэй байх юм. Тариалангийн бүс нутгууд байж байна. Одоо жишээ нь Булган, Төв аймаг гээд л зөндөө л олон тариалангийн бүс нутгууд байна, Сэлэнгэ гээд. Энэ тариалангийн бүс нутаг дараа жилд бүрэн бололцоотой байхад нь ямар дэмжлэг үзүүлэх ёстой юм гэсэн энэ зүйлүүд чинь энэ дотор бас орж ирмээр байна шүү дээ.

Хүнсний ногоотой холбоотой үйлдвэрлэлүүд. Намар болонгуут дахиад л бид нарт хавар бид нар тариалалтаа хийж чадаагүй, тийм болохоор дахиад нэг аж ахуйн нэгжүүдээ дэмжье ч гэдэг юм уу, эсвэл импортоор ногоо цагаа оруулна ч гэдэг юм уу. Аягүй бол бол тийм юм руу дахиад л орно шүү. Тэгэхгүйн тулд өнөөдөр тариаланчдаа, ногоочдоо, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээ хийж байгаа, тэр махны бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа энэ аж ахуйн нэгжүүд чинь намар хэд алдчихгүйн тулд арав, арван нэгэн сар гэхэд хүнд байдалд орчихгүйн тулд энийг дагасан, тэд нарыгаа дэмжсэн.

Ж.Ганбаатар: Адьшаа гишүүн үг хэлье.

Ш.Адьшаа: Энэ хуулийн төсөл зайлшгүй орж ирэх ийм нөхцөл байдал үүссэн л дээ. Тэгэхдээ энэ хуулийн төслийг ийм захиргааны аргаар ч юм уу, төрийн энэ олонхын бүлгийн шийдвэр маягаар ингэж оруулж ирвэл энэ чинь үр дүнд хүрэхгүй. Улам эдийн засгийг унагаах ийм бодлого болно шүү. Өнөөдрийн зах зээлийн зарчим, эдийн засгийн хөгжлийн агуулгатай зохицолсон ийм л хууль оруулж ирэх шаардлагатай байгаа юм.

Валютын нөөц 3.4 тэрбум доллар байна гэдгийг Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч нар хариуцлагатай хэллээ шүү. Өнөөдөр зохиомол хомстол бий болгох, зохиомол байдлаар эдийн засаг, зах зээлийн зарчмаар бус байдлаар л эдийн засгийг барих төрийн мөнгөний бодлого, эдийн засгийн бодлого

барина гэж байгаа бол энэ бол их том андуурал байхыг гэж бодож байна. Андуурал байх гэж бодож байна.

Өнөөдөр 20 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний валютыг улсын хилээр гаргахгүй тухай хуулийг батлах гэж байгаа юм байна. Энэ зөв байх гэж бодож байна. Гэтэл өнөөдөр гадаад улс орнуудаас ямар ч байсан мөнгийг татах, ямар мөнгө байсан ч энийг оруулж ирэх хуулийн зохицуулалтыг нь энэ хуулиар зохицуулж болохгүй юу? Зөвхөн нэг талыг барьсан, нэг талын хязгаарлалтыг тавьсан ийм бодлого чинь цаашдаа үр дүнд хүрэх үү? Өнөөдөр махыг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх тухай нэлээн том хэмжээний хөрөнгө санхүүг гаргах гэж байгаа юм байна л даа. Гэтэл өнөөдөр Монгол Улсад байгаа махны үйлдвэрүүд чинь дандаа гаднын үйлдвэрүүд байгаа. Тэрийг бэлтгэдэг ченжүүд байгаа. Гэхдээ өнөөдөр мах экспортлоход ямар бодлого барих вэ? Махны экспортоо хаах юм уу гэдэг асуудал дээр бас бодолцох шаардлагатай байна.

Дээр нь, Хүрэлбаатар гишүүн удаа дараа л энэ Монголбанкны удирдлагууд хууль зөрчсөн тухай, хулгай луйвар хийсэн тухай байнга ярьж байна. Энэ асуудалдаа энэ Улсын Их Хурлын удирдлагууд байна, Монгол Ардын Намын удирдлага бол энд яагаад цэг тавьж болдоггүй юм бэ. Үнэхээр Монголбанкны удирдлага хууль зөрчсөн, тийм хулгай хийсэн, төрийн мөнгө санхүүгийн бодлогыг гажуудуулсан асуудал ярьсан юм бол яагаад энэ хүмүүстэй хариуцлага тооцохгүй байгаа юм бэ? Сүүлийн нэг жил гаруй хугацаанд ХААН банктай холбоотой, Үндэсний хөрөнгө оруулалтын банктай холбоотой олон юмыг л энэ Лхагвасүрэн ерөнхийлөгч холбоотой ярилаа шүү дээ, Хүрэлбаатар гишүүн. Үнэхээр ийм хулгай луйвар байгаа юм бол танай намын удирдлагууд, Ерөнхий сайдаас энд хариуцлага тооцно гэсэн шүү дээ. Яагаад тооцохгүй байгаа юм.

Үнэхээр Монголын банк санхүүг дампууруулсан хууль зөрчсөн, хууль бус асуудал гаргасан юм бол энийгээ нэг тийш болгомоор байна. Үнэхээр хүнийг гүтгээд байгаа юм уу, аль эсвэл үнэхээр тийм хууль зөрчсөн асуудал байгаа юм уу гэдгийг албан ёсоор шийдэхийг би шаардаж байна, Их Хурлын гишүүний хувьд. Өнөөдөр Монголынбанк санхүү, түүний удирдлагатай холбоотой асуудал ийм хууль бус юм гарлаа гээд байхаар чинь бид банканд итгэх итгэл, төрд итгэх итгэл хаана байх юм. Энийгээ нэг тийш болгомоор байна гэдгийг хэлье.

Ж.Ганбаатар: Пүрэвдорж гишүүн үг хэлье.

Б.Пүрэвдорж: Би уул нь асуулт асуух байсан. Тэгээд үг хэлчихээд, дараа нь Их Хурал дээр бас асууна аа. Тэгэхээр махны үнэ тогтворжуулахад зориулж миний ойлгосноор бол 150 орчим тэрбум төгрөг зарцуулах юм байна. Үүгээрээ бас махны хангамжийг сайжруулаад төв суурин газар байгаа иргэдэд бас тодорхой үнэтэйгээр махаа борлуулах юм байна гэж ойлгож байгаа. Тэгэхээр үе үед, энэ бол дарга нарт л зориулсан зүйл. Өөрөөр хэлбэл энэ бол махны үйлдвэрийг ерөөсөө дэмжиж байгаа зүйл биш. Энэ дээр бол махны өдрүүд бараг л экспортод гаргачихсан нь илүү байдаг юм. Тэгэхдээ яах вэ, бас төр засагтайгаа хамтарч ажилладаг учраас махны компаниуд оролцоод Улаанбаатар хот болон төв, суурин газруудын иргэдэд мах хямд олгох талаар бол ажилладаг. Энэ дээрээ хүүгийн зөрүүг нь өгдөг л ийм л тогтолцоо л доо. Тэгээд нөөцийн мах гэж гардаг. Тэр нөөцийн мах бол цэвэр л энэ Улаанбаатар хотын даргын болон Засгийн газар үнэтэй мах иргэдэд өгч, бухимдлыг нь хүргэхгүйн тулд дарга нарт л зориулж хийгддэг зүйл. Бусдаар бол энэ үндэсний үйлдвэрлэлийг ерөөсөө дэмждэг зүйл биш шүү гэдгийг бас нэгдүгээрт хэлье гэж бодож байна.

Саяхан Хөдөө аж ахуйн сайд 400 тэрбум төгрөгийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 400 тэрбум төгрөгийг зээл болгож аж ахуйн нэгжүүдэд өгсөн. Энэ дээр бол махнаас бусад бүх хөдөө аж ахуйн салбарууд бүгдээрээ орчихсон байгаа. Би энийг яагаад махыг оруулаагүй юм бол гэж бодсон. Нэгдүгээрт бол ийм шийдвэр

ойрдоо гарч байсан юм байна. Хоёрдугаарт нь Монголбанкны мөнгөний бодлого дээр тусгагдсан энэ зүйлтэй харилцан хамааралтай байгаа учраас бас тодорхой хэмжээгээр хоорондоо мэдээлэл солилцоод, энэ асуудлыг оруулаагүй юм байна гэж ойлгосон. Тэгэхээр 2022 онд төрөөс мөнгөний талаар баримтлах бодлого баримт бичгийн хоёрдугаарт нь заалт байгаа. Энд бол Монголбанканд үүрэг өгсөн.

Уул уурхайн бус экспортыг дэмжих, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх гэж байж байгаа. Энэ заалтыг хэрэгжүүлэхийн тулд тэнд дотор байгаа протоколыг зайлшгүй үзэх ёстой. Тэр протоколоор ямар зүйл заасан бэ гэхээр, Монгол Улсад бол БНХАУ-ын хөрөнгө оруулалттай махны үйлдвэрүүд маш ихээр орж ирсэн. Тэгээд маш бага зардлаар махаа бэлтгээд гаргаад, ингээд үндэсний үйлдвэрлэгч нарыг зах зээлээс шахдаг ийм тогтолцоо байгаа. Тэгэхээр энэ махны үйлдвэрлэлийг дэмжихийн тулд 200 тэрбум төгрөгийг тэр аж ахуйн нэгжид 3 хувийн хүүтэйгээр зээл олгох замаар үндэсний аж ахуйн нэгжүүдэд, зөвхөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд зээл олгох ийм протокол тэр дотор байгаа.

Нэг зүйл хэлэхэд, махны үнэ тогтворжуулах энэ 150 тэрбум төгрөг 2022 онд Монголбанкны хэрэгжүүлэх ёстой мөнгөний бодлогын 2022 онд тусгачихсан тэр заалт хоёр хоорондоо, түүгээр нөхөхгүй шүү. Тус тусдаа хөрөнгө оруулалтууд, тус тусдаа санхүүжилт байх ёстой шүү гэдгийг бас анхааруулж хэлье л гэж бодож байна. Тэгээд Их Хурлын чуулган дээр мэдээж энэ асуудал орж ирнэ. Тэгэхэд яг тодорхой, Лхагвасүрэн дарга үнэ тогтворжуулахад хэдэн төгрөг зарц яаж зарцуулах юм, 2022 оныхоо мөнгөний бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд ямар хөрөнгө оруулалт яаж гаргах юм гэдгээ бас тодорхой тайлбар өгөөрэй гэж хэлэх хэлэх байна. Баярлалаа.

Ж.Ганбаатар: Гишүүд үг хэлж дуусласа. Санал хураалт явуулъя, Байнгын хорооны гишүүдийг анхааралтай байхыг хүсье.

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэрийн гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн хомстол, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нь дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Анхааралтай байхыг хүсье.

Санал хураалт

Байнгын хороон дээрээ засаад явчихсан нь зөв л дөө.

72.7 хувиар саналаар санал дэмжигдлээ.

Санал, дүгнэлтийг Ж.Бат-Эрдэнэ гишүүн Их Хурал дээр танилцуулна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан өндөрлөлөө. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ Б.БАТГЭРЭЛ